

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.99

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага	
General requirements for the protection and recovery service to the child victim of sexual abuse	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны дугаар сарын-ны өдрийн дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс хүчинтэй.

1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн (бэлгийн хүчирхийллийн) хохирогч хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, үйлчилгээний орчныг тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд тавих нийтлэг шаардлага, хэм хэмжээг тогтоож мөрдүүлэхэд оршино.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

Монгол улсын нутаг дэвсгэр дээр хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ ба хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг хүүхдийн эрхэд суурилсан, хохирогч төвтэйгөөр, мэргэжлийн түвшинд үзүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжид хяналт тавих, үнэлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд хэрэглэгдэнэ.

3 Норматив ишлэл

MNS 6418:2013 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага;
MNS 5852:2017 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага;
MNS 6949:2021 Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага;
MNS 6040:2019 Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага.

4 Нэр томъёоны тайлбар

Энэхүү стандартад заасан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

4.1 Хүүхэд¹

18 –аас доош насны бүх хүн;

Хүүхдийн ашиг сонирхол²

Хүүхдийн үндсэн эрх, хэрэгцээ, хувийн шинж чанар, нийгмийн сайн сайхан байдал, бие бялдар, сэтгэл хөдлөл, оюуны хөгжлийг хангах үндсэн шийдвэр;

¹НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенци, 1989

²АНУ болон Монгол улс хоорондын Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ, Хавсралт А.Тодорхойлолтууд, 15х

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг³

Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл;

4.4

Хохирогч⁴

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртсний улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал, ашиг сонирхол нь зөрчигдсөн, эсвэл бэлгийн хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүн;

4.5

Насанд хүрээгүй хохирогч

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртсний улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал, ашиг сонирхол нь зөрчигдсөн, эсвэл бэлгийн хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа 18 насанд хүрээгүй Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

4.6

Түр хамгаалах байр⁵

Хохирогчийг тодорхой хугацаагаар байрлуулан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газар;

4.7

Холбон зуучлах үйлчилгээ⁶

хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд нь оруулах, нөхөн сэргээхэд туслах зорилгоор холбогдох төрийн, төрийн бус байгууллагад зуучилж, хамтран үйлчилгээ үзүүлэхийг;

4.8

Хүчирхийллийн болзошгүй эрсдэл

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртөхөд хүргэж болзошгүй, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэх нөхцөл байдал;

4.9

Хохирогч төвтэй арга барил⁷

Насанд хүрээгүй хохирогчтой ажиллахдаа түүний эн тэргүүний хэрэгцээ шаардлага, ашиг сонирхол, өөрийн бодлоор шийдвэр гаргах эрхийг хүндэтгэн, ямар нэгэн хувийн дүгнэлтгүйгээр туслалцаа үзүүлэх, мэдээлэлд тулгуурласан сонголт хийхэд нь хохирогчид туслах, хохирогчийн амь нас, аюулгүй байх мэдрэмжийг сэргээхийг нэн тэргүүнд тавьж хохирогчийг санамсаргүй байдлаар дахин гэмтээх аюул учруулж болзошгүй бодлого, практикаас хамгаалах, гэмт хэргийн хохирогчдод нөлөөлөх хамт

³Эрүүгийн тухай хууль,

⁴Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.2

⁵Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.5

⁶Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.7

⁷Цагдаагийн байгууллагад хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зөвлөмж, 2022, хуудас 8

олон түшиглэсэн системийг боловсруулж хэрэгжүүлэхдээ хохирогчийн эрх, үзэл бодол, хэтийн төлөвлөгөө зэргийг тусгахыг чухалчлах;

4.10

Хоёрдогч хохирогч

Хохирогч хүүхэд хамгааллын ба нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад байгууллага, мэргэжилтэн, хувь хүний хариу үйлдлийн улмаар дахин хохирох;

4.11

Цогц үйлчилгээ⁸

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртсөн хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээ болох эмнэлгийн тусламж үйлчилгээ, түр хамгаалах байр, эрчимтэй кейс менежмент, аюулгүй байдлын төлөвлөгөө, хямралыг зогсоох, хохирогчид зөвлөгөө өгөх, хууль зүйн туслалаа үзүүлэх, ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх, сэтгэцийн эрүүл мэндийн эмчилгээ, боловсролд тасралтгүй хамрагдах, амьдрах ухааны сургалт ба бусад үйлчилгээг иж бүрэн үзүүлэх;

4.12

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ⁹

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртсөн ба өртөж болзошгүй хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагаа;

4.13

Хүүхдийн эрхийн ажилтан¹⁰

Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх бүхий ажилтан, албан тушаалтан;

4.14

Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Цагдаа, шүүхийн тогтолцоонд хүүхдэд ээлтэй орон зайг хариуцан ажиллах, хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийг хянан шалгах ажиллагаанд томилогдсон албан хаагч, мөрдөгч;

4.15

Хүүхдэд ээлтэй орон зай¹¹

Хохирогч хүүхдэд хамгаалах ба нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хүүхдээс мэдүүлэг авах үед хүүхдэд тав тухыг мэдрүүлсэн, шаардлагатай халамж, тусламж үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлсэн өрөө, өрөөний тусгаарлагдсан хэсэг, түүнд ажиллах мэргэжилтнүүдийн ур чадвар, мэргэжлийн хандлага бүхий орчин;

4.16

Аюулгүй байдлыг хангах¹²

Насанд хүрээгүй гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, сэтгэл зүйг хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй арга хэмжээ;

⁸ Цагдаагийн байгууллагад хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зөвлөмж, 2022, хуудас 8

⁹ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.6

¹⁰ Хүүхэд хамгааллын тухай хууль, 4.1.7

¹¹ Мөн тэнд

¹² Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

4.17

Эмнэлгийн яаралтай тусламж

Хүний амь насанд аюултай өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэхэд чиглэсэн хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн тусламж.

4.18

Эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтний илгээсэн үйлчлүүлэгчид үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ;

4.19 Бичгээр баталгаажсан таниулсан зөвшөөрөл (Informed consent)

Зөвшөөрөл өгөх эрхзүйн чадамж бүхий, тухайн үйлчилгээний талаар мэдэх, ойлгох хэмжээний насанд хүрсэн, хувь хүний сайн дураар өгсөн зөвшөөрөл;

4.20

Аман зөвшөөрөл (Informed assent)

Бичгээр баталгаажуулаагүй хувь хүний сайн дурын үндсэн дээр өгсөн зөвшөөрөл ба зөвшөөрөл өгч буй хүнээс эрх зүйн чадамжтай байхыг шаардахгүй; (хүүхэд ойлгосон/зөвшөөрснөө илэрхийлж толгой дохих, за, тэгье гэж гэж хэлэх, сонсголын бэрхшээлтэй хүүхэд ойлгосноо гарын дохио зангаагаар илэрхийлэх зэргээр үгэн ба үгэн бус хэлэмжээр илэрхийлэгдэнэ).

4.21

Илчлэх

Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаараа мэдээлэх үйл явц; (Илчлэх нь нэг удаагийн биш нилээд олон удаа үргэлжлэх урт хугацааны үйл явц байдаг).

4.22

Заавал мэдээлэх үүрэг (Mandatory reporting)

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй хүүхдийн талаар таамагласан, мэдсэн хүн, хуулийн этгээд энэ талаар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, сум, баг, хорооны Засаг дарга, хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх утасны үйлчилгээнд нэн даруй мэдээлэх;

4.23

Кейс файл (Хувийн хэрэг)

Хүүхдийн хувийн, гэр бүлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, үйлчилгээ эхлэх үеийн, нөхцөл байдлын үнэлгээ хийх, төлөвлөх, хүргэх, үнэлэх, хаах, үйлчилгээг зогсоосон, шилжүүлсэн, холбон уузчилсан кэрэг холбогдох нотлох бриямт бүхий нууцлалтай материал;

4.24

Кейс менежмент

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, гэр бүлд чиглэсэн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг тодорхой үе шатаар хүргэх, зохицуулах, хяналт тавих мэргэжлийн үйл ажиллагаа;

Хохирогч хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчид хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд, тохиромжтой хэлбэрээр, системтэй шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх арга зам¹³;

4.25

Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал

Нийгэм, сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл түр хямарсан байдал;

4.26

Ураг төрлийн хүчин

Хохирогчтой цусан болон ойрын төрөл садангийн холбоотой хэн нэгэн этгээд түүнийг эрхшээлдээ оруулах зорилгоор эрх мэдэл, давуу талаа ашиглан, гэр бүлийн ариун журамт ёс, хайр, хүндэтгэл, итгэлийг эвдэж, хүний халдашгүй дархан байдал, эрх, эрх чөлөөг зөрчиж, бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, садар самууны шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан гэмт үйлдэл;

4.27

Үйлчилгээ үзүүлэх байгууллага

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд энэ стандартад заасан үйлчилгээг үзүүлэх байгууллага; (Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх ӨЭМТ, Нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байр, төрийн бус байгууллага, аймаг дүүргийн)

4.28

Мөрдөн шалгах ажиллагаа

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын зөвшөөрлөөр, эхсүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөгч бие даан явуулах ажиллагаа;

4.29

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, түүнд прокурор хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа;

4.30

Форензик ярилцлага

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, хүүхэд хамгааллын тусламж үйлчилгээний тогтолцоонд салбар дундын хамтарсан багаас шударга бөгөөд оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг хүүхдээс авах зорилгоор хийж буй ярилцлага;

4.31

Мэдээлэл хуваалцах журам

Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчаас ямар мэдээллийг цуглуулах, үүнээс ямар мэдээллийг нь хэрэглэх, ямар хэлбэрээр хуваалцах (аман, бичгээр, электрон), хадгалах хэм хэмжээг тодорхойлсон баримт бичиг;

4.32

Нийгмийн ажилтан

Баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажлын үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтан;

4.33

Сэтгэл зүйч

Эрүүл мэнд, боловсролын, бусад салбарт ажиллаж байгаа сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий их, дээд сургуулийг сэтгэл зүйн мэргэжлээр төгссөн мэргэжилтэн;

4.34

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ

Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан төрөөс өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон үндсэн мэргэшлийн зарим нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг иргэн, гэр бүл, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор харьяалах нутаг дэвсгэрт байгаа хүн бүрд нь нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр үзүүлэх үйл ажиллагаа;

4.35 Эмнэлгийн мэргэжилтэн

Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежийг төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хүний их, бага эмч, шүдний их эмч, уламжлалт анагаах ухааны их эмч, сувилагч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сэргээн засах чиглэлийн мэргэжилтэн⁴

4.36

Өсвөр үеийн эмч

Өсвөр үеийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн эмчийг;

5 Үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

5.1

Хүүхдийн нэр төр, эрх ашгийг хамгаалах ба аюулгүй байдлыг хангах зарчим

Хохирогч хүүхэд ямар нэг байдлаар хүүхэд хамгааллын ба цагдаагийн байгууллагатай холбогдсон үед хүүхдийн нэр төр, эрх ашгийг хамгаалах асуудлыг нэн тэргүүнд тавьж, хүүхдэд үйлчилгээ үзүүлэх ба хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийг байнга хамгаалалтад байлгана.

5.2

Хүүхдийн нууцлалыг хангах зарчим

Хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны турш үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэргэжилтнүүд хүүхдийн хувийн мэдээллийг нууцлах бөгөөд хадгалах, хуваалцах дүрэм журмыг баримтлан ажиллана.

5.3

Хохирогчийг үл буруутгах ба хоёрдогч хохирол учруулахаас сэргийлэх зарчим (do no harm)

Хүүхдэд үйлчилгээ үзүүлж буй бүх мэргэжилтэн хүүхэдтэй холбоо тогтоох, ярилцлага хийх, зөвлөгөө мэдээлэл өгөх, дэмжлэг туслалцаа үзүүлэх үедээ хүүхдийг болсон үйл явдалд буруутгасан хандлага, үг үйлдэл гаргахгүй байхад анхаарна.

5.4

Хүүхдэд ээлтэй орон зай бүрдүүлэх зарчим

Хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх бүх байгууллага хүүхдэд ээлтэй орон зай бүхий орчин нөхцлийг бүрдүүлнэ.

5.5

Мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх зарчим

Хүүхдэд үйлчилгээ үзүүлж буй байгууллагын ажилтнууд нь (эмч, цагдаа, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, мөрдөгч, хуульч, өмгөөлөгч, багш ба бусад) бэлгийн хүчирхийллийн динамик, хохирогч хүүхдэд илрэх шинж тэмдгийн талаар сургалтад хамрагдаж, бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллах арга зүй, ур чадварт суралцсан байна.

5.6

Салбар дундын хамтын ажиллагаанд тулгуурласан цогц үйлчилгээг шуурхай, тогтвортой хүргэх зарчим

Хохирогч хүүхдэд учирсан олон талт хохирлыг арилгах, хамгаалах, нөхөн сэргээх, цаашид үүсч болох эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн цагдаа, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал ба бусад холбогдох төрийн ба төрийн бус байгууллагын зүгээс цогц үйлчилгээг шуурхай, тогтвортойгоор үзүүлнэ.

6 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн ба өртсөн байж болзошгүй талаар мэдээлэл хүлээх авах

6.1 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй мэдээлэл хүлээн авсан байгууллага, албан тушаалтан хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд нэн тэргүүнд анхаарлаа хандуулж, хариу арга хэмжээ авах хугацаанд эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээнд хамруулна.

6.2 Эмнэлгийн яаралтай болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авахдаа тохиолдол 72 цагийн дотор болсон эсэх ба хүүхдийн тухайн үеийн эрүүл мэнд, сэтгэл зүйн байдлыг харгалзан үзнэ.

6.3 Бэлгийн хүчирхийллийн сүүлийн тохиолдол 72 цагийн дотор болсон ба/эсвэл хүүхдийн бие махбод өвчин зовиур илэрч буй, сэтгэл санааны байдал хүнд байгаа тохиолдолд эмнэлгийн түргэн тусламжинд нэн даруй хамруулна.

6.3.1 Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн хүүхдийн бие, сэтгэл зүйн байдлыг үнэлж, сэтгэл зүйн дэмжлэгийг үзүүлнэ.

6.3.2 Хохирогч хүүхдэд бэлгийн хүчирхийллээс үүдэлтэй сэтгэл хөдлөл, зан үйлийн хямралт шинж тэмдэг (ухамсарт ухаан баларталт, амиа хорлох тухай бодол, шок) илэрсэн тохиолдолд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд яаралтай холбон зуучилж, тус үйлчилгээнд хамрагдах хүртэл хугацаанд хяналтанд байлгана.

6.4 Бэлгийн хүчирхийллийн сүүлийн тохиолдол 72 цагаас өмнө болсон, хүүхдийн бие махбод, сэтгэл зүйд өвчин зовиур илрээгүй, хүүхдийн сэтгэл зүй тайван байгаа тохиолдолд эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээнд (бүтэн биеийн үзлэг/шүүхийн шинжилгээний үзлэг) хамруулна.

6.5 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн ба өртсөн байж болзошгүй талаар мэдээлэл хүлээн авсан үйлчилгээний байгууллагын ажилтан холбогдох мэдээллийг бүртгэлийн хуудсанд үнэн зөв, бүрэн бүртгэж хөтөлнө. Бүртгэлийн хуудсанд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- Мэдээлэл хүлээн авсан хугацаа (он, сар, өдөр);
- Мэдээлэл өгсөн хүний нэр, нас, хүйс, хүүхэдтэй ямар хамааралтай;
- Хүүхдийн нас, хүйс болон гэр бүлийн мэдээлэл;
- Хүчирхийлэл үйлдэгдсэн орчин, арга хэлбэр, үйл явц (мэдээлэл өгч буй хүний дүрсэлж буйгаар);
- Хүчирхийлэл үйлдэгчийн тухай мэдээлэл, хүүхэдтэй ямар хамааралтай
- Бусад нэмэлт мэдээлэл (хүүхдэд учирсан эрүүл мэндийн, сэтгэл зүйн болон бусад хор хохирлын байдал);
- Мэдээлэл хүлээн авсан ажилтан гарын үсэг зурна.

6.6 Нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал хариуцсан болон эмнэлгийн мэргэжилтэн шаардлагатай бичиг баримт, бусад эд зүйлийг аль болох асуумжид хавсаргах, хавсаргах боломжгүй бол байгаа газрыг тодорхойлох зэрэг өөрийн хэмжээнд устах, гэмтэхээс сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авсан байна.

6.7 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар мэдээллийн бүртгэлийг цоожтой шүүгээнд, нууцлал хангасан нөхцөлд хадгална. Хүүхдэд үзүүлэх үйлчилгээг тодорхойлох, хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт болохуйц чухал ач холбогдолтой тул бүртгэлийг бүрэн дүүрэн, үнэн зөв тэмдэглэнэ.

6.8 Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн орчинд өөр хүүхэд байгаа бол мэдээлэл хүлээн авсан ажилтан тэдний аюулгүй байдал, хамгаалуулах хэрэгцээг хангах арга хэмжээг авна.

6.9 Хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч болох нь өндөр эрсдэлтэй, эмзэг кейст тооцогддог тул мэдээлэл хүлээн авсан хүүхэд хамгааллын байгууллагын ажилтан багийн ахлагч болон мэргэжлийн удирдагчид заавал мэдэгдэж, арга зүйн дэмжлэг заавар авна. Үүнд:

- Хамтарсан багийн ахлагч болон сум, хорооны засаг даргад;
- Сургуулийн хүүхэд хамгааллын багийн ахлагч болох сургуулийн захиралд
- Нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байрны ажилтан ахлах мэргэжилтэнд;
- Хүүхдийн тусламжийн утас 108 ийн мэдээлэл хүлээн авсан ажилтан ахлах мэргэжилтэнд гэх мэт.

6.10 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар өөрөө мэдээлсэн, эцэг эх, асран хамгаалагч ба бусад гэрч мэдээлсэн тохиолдолд эмнэлгийн яаралтай тусламжийн дараа цагдаагийн байгууллагад заавал мэдээлнэ.

7 Хохирогч хүүхдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх

7.1 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн хохирогч хүүхдэд нас хүйс харгалзахгүй, бичиг баримт шаардахгүй, дугаар, харьяалал харгалзахгүй яаралтай тусламжийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.

7.2 Эмнэлгийн яаралтай, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлгийн хүчирхийллийн хохирогч болсныг илтгэх хүүхдийн өгсөн мэдээлэл, хүүхдийн биеийн ба сэтгэл зүйн байдал, хохирогчийн эрүүл мэндэд учирсан хохирол, гэмтлийн байдлыг баримтжуулан тэмдэглэж авна.

7.3 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдлыг цагдаагийн байгууллагад мэдэгдсэн эсэхийг холбон зуучилсан байгууллагын мэргэжилтнээс тодруулж хэрвээ мэдээлээгүй тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдээлнэ.

8 Цагдаагийн байгууллагын шуурхай арга хэмжээ

8.1 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн, эсвэл өртсөн байж болзошгүй тухай мэдээллийн дагуу цагдаагийн байгууллага хэргийн газар очиход хохирогч хүүхдэд эмнэлгийн яаралтай анхан шатны тусламж үзүүлэхийг нэн тэргүүнд тавьж, шүүхийн үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг дараа нь зохион байгуулна.

8.2 Бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг хуульд заасан арга хэрэгслээр таслан зогсоож, хохирогч хүүхдийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул учирсан, эсхүл тухайн орчин нь аюултай гэж үзвэл хохирогчийг хамгаалах арга хэмжээг¹⁴ даруй авч хэрэгжүүлнэ:

8.2.1 Цагдаагийн байгууллага, хамтарсан багийн хэсгийн ахлагч хүүхдийн нөхцөл байдалд аюулын зэргийн үнэлгээ хийнэ.

8.2.2 Хохирогчийг хамгаалах арга хэмжээг холбогдох хууль¹⁵, нийтлэг шаардлагын¹⁶ дагуу авч хэрэгжүүлнэ.

8.3 Цагдаагийн байгууллага хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эрт оролцох тусам хэргийн газар болон хүүхэд, түүний эд зүйлд үлдсэн баримт нотолгоо алдалгүйгээр цуглуулах боломж бүрдэнэ. Энэ үйл явцын хүрээнд цагдаа нь мөрдөн байцаалт, яллах дүгнэлтэд хэрэглэх баримт нотолгоо цуглуулахын тулд эмнэлгийн мэргэшсэн албаар хүүхдийн биед шүүх эмнэлгийн үзлэг хийлгэнэ.

9 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртснийг таамаглах ба тодорхойлох

9.1 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд талаар эцэг эх, асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, цагдаагийн ажилтан ба бусад хүмүүст өөрөө мэдээлсэн тохиолдолд хүүхэдтэй ярилцахад тохиромжтой аюулгүй орчин нөхцөлд хамт байж, хүүхдийн хэлж ярьж буйг анхааралтай сонсохын хамт түүнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэн, холбогдох үйлчилгээ, тусламж, дэмжлэг арга хэмжээний талаар мэдээлэл өгч, хүүхдийн асуултанд хариулах замаар хүүхдэд итгэж байгаага илэрхийлэн, цаашдын тусламж үйлчилгээнд холбон зуучилна.

9.2 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар өөрөө мэдээлээгүй ч энэ нь БЗДХ, жирэмслэлт, зулбалт зэрэг шинж тэмдгээр илэрч буй тохиолдолд үүнийг илрүүлсэн ажилтан хүүхэдтэй уулзан, илэрсэн шинж тэмдгийн талаар ярилцаж, хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг тодруулахыг хичээнэ.

9.3 Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон бусад хүмүүс хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртснийг хүүхдийн бие махбод, сэтгэл хөдлөл, зан үйлд илрэх зарим шинжээр танин мэдэж, таамаглаж болно. Үүнд:

9.1.1 Хүүхдийн зан үйлд нас, хөгжлийн түвшинд тохирохгүй бэлгийн үг үйлдэл илрэх;

9.1.2 Гэнэтийн ойлгомжгүй зан үйл гаргах, ж нь сургуульдаа явахаас татгалзах, хэн нэгэнтэй хамт үлдэхээс зайлсхийх;

9.1.3 Хүүхдийн биемахбод, сэтгэл санаа, зан үйлд анхаарал татахуйц шинж тэмдгүүд ажиглагдах: бага насны хүүхэд гэнэт орондоо шээдэг болох, загатнах, хөхрөлт, өвдөлт зовиур, биеийн ерөнхий эрүүл мэнд муудах;

9.4 Бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг таамаглах (В хавсралт) шинж тэмдгээс нэг болон олон шинж тэмдэг илэрсэн тохиолдолд бэлгийн хүчирхийллийн тохиолдол байж болохыг таамаглана. Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй (хэл яриа, сонсголын бэрхшээлтэй, оюуны бэрхшээлтэй) хүүхдийн тохиолдолд эдгээр шинж тэмдэг нь бэлгийн хүчирхийллийн тохиолдол байж болох тул илүү няхуур хандана.

¹⁴ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 24 ба 25-р зүйлд заасан үүргийг хэрэгжүүлнэ.

¹⁵ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

¹⁶ Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах нийтлэг шаардлага

9.5 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухай мэдсэн эцэг эх, асран хамгаалагч ба холбогдох албан тушаалтан хуульд заасны дагуу орон нутгийн цагдаагийн ба хүүхэд хамгааллын байгууллагад заавал мэдээлнэ.

9.6 Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч бэлгийн хүчирхийллийн талаар өөрөө мэдээлээгүй, энэ талаар гэрч байхгүй, мөн хүүхдийн бие махбодод хүчирхийллийн үр дагавар байж болох шинж тэмдэг илрээгүй тохиолдолд бусад шинж тэмдэгт үндэслэн хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж шууд тодорхойлж болохгүй ба дараах арга замаар бэлгийн хүчирхийллийн талаар тодруулахыг хичээнэ.

9.6.1 Бэлгийн хүчирхийллийн талаар таамаглаж буй мэргэжилтэн хүүхэд хүчирхийллийн тухай ярих, илчлэхэд тохиромжтой, аюулгүй, тайван орчин нөхцлийг бүрдүүлнэ.

9.6.2 Хүүхдийн итгэдэг хүнтэй уулзаж хүүхдэд эрүүл мэндийн болон аюулгүй байдлын асуудал байгаа эсэхийг тодруулна.

9.6.3 Хүүхэд тохиолдсон зүйлийн талаар ярихгүй байгаа шалтгааныг олж мэдэхийг хичээнэ. (Хүүхэд хамт байгаа, эсвэл дагуулж яваа хүнээсээ хамаараад ярихгүй байх, орчин хангалттай аюулгүй байж чадахгүй учраас ярихгүй байх, эсвэл мэргэжилтэнд итгэхгүй байх гэх мэт)

9.6.4 Хүүхэд тухайн мэргэжилтэнд итгэхгүй байгаа нь тэр мэргэжилтний буруу биш бөгөөд энэ тохиолдолд хүүхдийг өөр мэргэжилтэнд холбон зуучилж болно.

9.7 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар өөрөө хэлээгүй, илрүүлээгүй үед эрүүл мэндийн болон гэр бүл, орчны, нийгмийн асуудал, хүүхдийн зан үйл, эрсдэлт зан үйлийг илрүүлэх үүднээс ДЭМБ-с зөвлөсөн HEADASS аргачлалыг хэрэглэж болно. Хавсралт E

9.7.1 Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсон, жирэмсэн, жирэмсэн байж болзошгүй, амиа хорлох бодол, оролдлого, хорт зуршил байгаа зэргийг тооцож эрсдэлтэй гэж үзвэл шаардлагатай эмнэлгийн болон нийгэм сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэнд, хамгаалал, хуулийн тусламж үйлчилгээнд холбон зуучлах шаардлагатай.

9.8 Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй анх холбоо тогтоож ярилцлага явуулахдаа бэлгийн хүчирхийлэлд өртсөнтэй холбоотой нэр төр, алдар хүнд, эрүүл мэнд, сэтгэл санаа, эд хөрөнгийн ямар хохирол, хор уршиг учирсан талаар тодруулсан байна. Энэ нь хохирогч хүүхэд хохиролоо нэхэмжлэх, нэхэмжилсэн хохирлоо нотлон баримтаар тогтолгох зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухал ач холбогдолтой.

10 Хохирогч хүүхдэд хийх эрүүл мэндийн ба шүүх шинжилгээний үзлэг

10.1 Хохирогч хүүхдийн эсрэг үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн шинжээс шалтгаалан шүүх эмнэлэг, шүүх сэтгэц эмгэг судлал, сэтгэц судлалын шинжээчээр шинжилгээ хийлгэх хүсэлтийг мөрдөгч гаргана.

10.1.1 Хохирогч хүүхдийн эсрэг үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн ул мөр, хүүхдийн биед учруулсан хор хохирлыг тогтоох үүднээс шүүх шинжилгээний үзлэг хийнэ.

10.1.2 Хохирогч хүүхдийн оюун ухааны бэрхшээлийг тогтоох шаардлагатай гэж үзвэл сэтгэц эмгэг судлалын шинжилгээ хийнэ.

10.1.3 Хохирогч хүүхдийн сэтгэл санаанд учирсан хохирлыг тогтоолгохын тулд сэтгэл зүйн шинжилгээ хийнэ.

10.1.4 Хүүхдийн насыг гэрчлэх бичиг баримт байхгүй, хүүхдийн насыг санаатайгаар нуух, байгаа бичиг баримт эргэлзээ төрүүлж байвал нас тогтоох шинжилгээ хийнэ.

10.2 Хүүхдэд хийх шүүх шинжилгээний үзлэг нь хүүхдийн бие махбодын бүхий л хэсгийг хамрахаас гадна цаг хугацаа их зарцуулагддаг, хүүхдэд тав тухгүй байдаг тул олон удаа үзлэг хийж хүүхдийг дахин тухгүй байдалд оруулахаас сэргийлж, хүүхдэд анхан шатны болон бусад эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад цуглуулсан нотлох баримтыг

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтын хэмжээнд авч үзэх боломжийг судалж эрэлхийлнэ.

10.3 Эрүүл мэндийн бүтэн биеийн үзлэгийг хийх хугацаа алдснаар бэлгийн хүчирхийллийн улмаас бие махбодод учирсан бэртэл гэмтэл, ба нотлох баримтын шинж тэмдэг өөрчлөгдөх, арилах эрсдэлтэй тул аль болох нэн даруй хамруулна.

10.4 Шүүхийн шинжилгээний үзлэг хийх мэргэжилтэн нь хүүхдийн нас, сэтгэхүйн хөгжлийн онцлогийн талаар мэдлэгтэй, хүүхдийн нас, сэтгэхүйд тохируулан харилцах чадвартай байхын хамт хохирогч хүүхдийн бие махбод, сэтгэл зүйд дахин гэмтэл учруулахаас зайлсхийж, хохирогч төвтэй тусламж үйлчилгээ үзүүлнэ.

11 Хохирогч хүүхэдтэй форензик ярилцлага хийх

11.1 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй хүүхдэд тохиолдсон хэргийг хянан шийдвэрлэх, хамтарсан багаас хүүхдэд шаардлагатай тусламж үйлчилгээг тодорхойлохын тулд тухайн хэрэг, тохиолдлын талаарх мэдээллийг хүүхдээс авах зорилгоор форензик ярилцлагыг хийнэ.

11.2 Форензик ярилцлагыг мэргэшсэн (форензик ярилцлага хийх талаар мэргэшүүлэх тусгай сургалтад хамрагдсан) мэргэжилтэн (хүүхдийн асуудал хариуцсан цагдаагийн ажилтан, хүүхдийн эрхийн байцаагч, хамтарсан багийн гишүүн) удирдан явуулна.

11.3 Хүүхэдтэй дахин ярилцлага хийхээс урьдчилан сэргийлэх үүднээс гэмт хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бүхий л мэдээллийг энэ ярилцлагаар олж мэдэхийг зорино.

11.4 Форензик ярилцлагыг хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохируулан, соёлын ба гендерийн мэдрэмжтэй, бодит баримт, нотолгоог эрэлхийлсэн, хуульд нийцсэн байдлаар хөтлөн явуулна.

11.5 Форензик ярилцлагыг хүүхдэд ээлтэй орчинд явуулна.

11.6 Хохирогч хүүхэд гадаадын эсвэл харьяалалгүй бол төрөлх хэлээр, хос хэлтэй бол сонгосон хэл дээр нь ярилцлагыг хийнэ. Гадаад хэлээр ярилцлага хийх үед орчуулагчийг биеэр байлцуулан ярилцлагыг явуулна. Энэ тохиолдолд орчуулагчийг дараах байдлаар бэлтгэнэ.

- Нууц хадгалах гэрээ байгуулах;
- Эмзэг, хөндүүр агуулгыг орчуулах шаардлагатай талаар ярилцах;
- Хүүхдийн хэлж ярьж буй зүйлийг үг бүрчлэн байгаагаар нь орчуулах ба нэмж тайлбар хийхгүйг анхааруулах;
- Ярилцлагын явцад мэргэжлийн хэр хэмжээгээ хадгалахыг сануулах.

11.7 Форензик ярилцлагыг А хавсралтад заасан удирдамжийн дагуу үе шатаар явуулна.

12 Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх (Кейс менежмент)

12.1 Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхдийн оршин байгаа газрын хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага үзүүлнэ.

12.2 Кейс менежмент хариуцсан ажилтнуудыг бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулан, заавал эзэмших ёстой мэргэжлийн мэдлэг, ур чадварт сургана.

12.3 Бэлгийн болон гендерт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүүхдийг өндөр эрсдэлтэй кейс гэж үзнэ. Хохирогч хүүхдийн талаарх анхны мэдээлэл/үнэлгээнд үндэслэн хүүхдийн эмзэг байдал, эрсдлийн түвшин, яаралтай тусламж үйлчилгээг тогтоож, бүртгэл, мэдээлэлд суурилсан зөвшөөрөл авч, кейс менежментийн хэрэгцээг тодорхойлно.

12.5 Хохирогч хүүхэдтэй “Даван туулагч төвтэй” арга зүйг баримтлан ажиллана.

12.5.1 Хүүхдийн туулсан зүйлийг хүлээн зөвшөөрөх: Хүүхдийн илэрхийлж буй мэдрэмж (уурлах, айх, гуниглах гэх мэт)- ийг ойлгож, болсон явдлын талаар өөрийнх нь тайлбарт итгэж, түүний туулсан зүйл, гаргасан шийдвэрийг шүүж буруутгахгүй.

12.5.2 Хүүхдийг дэмжихийг хичээх; Хүүхэд бэлгийн хүчирхийллийн улмаас амссан зовлонгоос болоод бие, сэтгэлээ хянах чадваргүй байгаа бол үйлчилгээ үзүүлэх явцад шийдвэр гаргах чадамжтай, том хүүхдээр өөрөөр нь шийдвэр гаргуулах байдлаар, өөрийгөө хянах чадварыг нь сэргээхийг хичээнэ.

12.5.3 Хүүхдийн давуу талыг онцгой анхаарах: Хүүхэд дасан зохицох, асуудал шийдвэрлэх чадвартайг хүлээн зөвшөөрч, тэдгээр чадварыг нь дэмжиж чадваржуулахад анхаарна.

12.5.4 Хүүхэдтэй тогтоосон холбоог хадгалах: Хүүхэд, түүнд тусалж буй ажилтан хоёрын хоорондын итгэлцэл бүхий эерэг харилцаа холбоо нь хүүхдийг илааршихад эерэгээр нөлөөлнө.

12.6 Кейс ажилтан нь хохирогчийн мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах талаар бүрэн бэлтгэлтэй байж, мэдээллийг зөвхөн холбогдох мэргэжилтнүүдийн хүрээнд зохих журмын дагуу хуваалцана.

12.6.1 Кейсийн маягыг кодолж хэний мэдээлэл болохыг таних боломжгүй байдалтай болгоно.

12.6.2 Кейс файлыг цоожтой шүүгээнд, ангилан хадгална.

12.6.3 Хохирогч хүүхдийг тохиолдсон зүйлийг дахин, дахин ярьж хоёрдогч хохирогч болгохоос урьдчилан сэргийлж, хамтарсан багийн гишүүд, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны мэргэжилтнүүд мэдээллийг журмын дагуу хуваалцана.

12.6.4 Кейс ажилтан хүүхдийн хувийн мэдээлэлтэй ямар ажилтан, албан тушаалтан, хэдэн сарын хэдний өдөр танилцсан буюу хуваалцсан талаар бүртгэлтэй байна.

12.6.5 Кейс ажилтан хүүхдийн хувийн мэдээллийг хуваалцсан ажилтан, албан тушаалтан бүртэй нууцлалын гэрээ байгуулж, журмыг танилцуулна.

12.7 Кейс менежментийн үйл явцын үе шат тус бүрт болон бэлгийн хүчирхийлэл үйлдэгч нь гэр бүлийн аль нэг гишүүн, садан төрөл эсвэл хөршийг сэжиглэж байгаа тохиолдолд ярилцлага хийх газрыг онцгой анхааралтай сонгох хэрэгтэй.

12.8 Хүчирхийлэл үйлдэгчийн төрөл садан, ойрын хамсаатан хүүхэдтэй ойр байсаар байгаа бол хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлаж аюулгүй байдлын хамгаалалтанд авахаар цагдаагийн байгууллагад хандана.

12.9 Кейс менежер нөхцөл байдлын үнэлгээгээр хохирогч хүүхдийн тухайн үеийн байдлыг тогтооно.

12.9.1 Нөхцөл байдлын үнэлгээг хийхийн өмнө хохирогч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид тэдний эрх, үүргийг танилцуулж, үнэн зөв мэдээлэл өгч, эрсдэлийг зөв тооцож, одоогийн байдалд зөв үнэлгээ хийснээр хуульд заасан тусламж, үйлчилгээ авах хэрэгцээ, боломжийг тодорхойлох, хуулийн байгууллагад нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх чухал ач холбогдолтой гэдгийг тайлбарлаж өгнө.

12.9.2 Нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ хохирогч хүүхдийн дараах дөрвөн талын хэрэгцээг анхаарна.

- Хүүхдийн аюулгүй байдал, хамгааллын хэрэгцээ;
- Хүүхдийн эрүүл мэнд, эмнэлгийн хэрэгцээ;
- Хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн хэрэгцээ;
- Хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчийн хууль эрх зүйн туслалцаа авах хэрэгцээ.

12.9.3 Хүүхдийн амьдарч буй өрх, гэр бүлд байгаа бусад хүүхдэд учирч болох бэлгийн хүчирхийллийн болзошгүй эрсдлийг үнэлэн дүгнэнэ.

12.9.3.1 Нөхцөл байдлын үнэлгээний үр дүнд үндэслэн хохирогч хүүхдийн бодит хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг үзүүлэх санал зөвлөмжийг боловсруулан үнэлгээнд тусгана.

12.9.3.2 Хүүхдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ болон эрүүл мэндийн анхан шатны тусламж, бүтэн биеийн үзлэг, эмч мэргэжилтний тэмдэглэл, хавсаргасан нотлох баримт, ярилцлагын тэмдэглэл зэргийг хүүхдийн хувийн хэрэгт хавсаргана.

12.9.3.3 Хохирогч хүүхдийг ямар ч тохиолдолд гэрт нь эсвэл хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийн байгаа болон тэрхүү этгээдийн очиж болохоор газар буцааж болохгүй.

12.9.3.4 Хүүхдийг бэлгийн зүй бус харьцаанд нэмж эсвэл үргэлжлүүлэн өртөх эсвэл өшөөгөө авахаар гэмт этгээд хүүхэдтэй дахин зүй бус харьцах эрсдэлээс хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ (жишээ нь хамаатан садан) болон хүүхэд асрах мэргэжлийн байгууллагад байлгах замаар нэн даруй хамгаална.

12.9.3.5 Хүүхдийг гэрээс нь авч явах нь түүнийг хүчирхийлэлд дахин өртөхөөс сэргийлж байгаа арга хэмжээ болохоос, түүнийг буруутган эсвэл шийтгэж байгаа хэрэг биш гэдгийг хүүхдэд ойлгуулж, тайвшруулна.

12.10 Хохирогч/даван туулагч хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс гадна дараах төрлийн дарамтанд өртөж хоёрдогч хохирол амсах эрсдэлтэй байдаг тул хүүхэд, түүний эцэг эхтэй байнгийн холбоо харилцаатай байж шаардлагатай дэмжлэг тусламжийг зохицуулан үзүүлнэ.

12.10.1 Гэр бүл, хуулийн байгууллагынхан болон бусад хүмүүсийн зүгээс гэр бүл, ойр дотныхондоо хэлээгүй гэж буруутгагдах;

12.10.2 Мэдүүлгээ өөрчлөхийг шаардсан ятгалга, сүрдүүлэг, дарамт заналхийлэлд өртөх;

12.10.3 Гэр бүлийнх нь харилцаанд гүнзгий өөрчлөлт орж, ах дүүс үл ойлголцох, гэр бүл салах;

12.10.4 Хүчирхийлэгч нь тэжээн тэтгэгч тохиолдолд гэр бүл эдийн засгийн хувьд дарамтан орох, гэр бүл орлогогүй болох;

12.10.5 Хэргийн нууцлал алдагдах зэргээс үүдсэн нэр төр, алдар хүндэд үүсэх эрсдлээс айх;

12.10.6 Өсвөр насны хохирогчийн хувьд сургуулиа орхих, гэр орноосоо дайжиж дахин гэмт хэргийн хохирогч болох, эрт гэрлэх, хүүхэд төрүүлэх, биеэ үнэлэх зэрэг сөрөг үр дагавар үүсэх

13

Хохирогч хүүхдэд үзүүлэх үндсэн үйлчилгээ

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд болон түүний эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдэд учирсан олон талт сөрөг үр дагаварыг арилгах зорилгоор кейс төлөвлөгөөнд тусгагдсан дараах цогц үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Аюулгүй байдлын хамгаалалт;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээ;
- Сэтгэл зүйн үйлчилгээ;
- Нийгмийн халамжийн үйлчилгээ;
- Боловсролын үйлчилгээ;
- Хууль, эрх зүйн туслалцаа;
- Холбон зуучлах үйлчилгээ.

13.1

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг аюулгүй байдлын хамгаалалтанд авах¹⁷

13.1.1 Хүүхдийг тусгай хамгаалалтад авах арга хэмжээг цагдаагийн алба хаагч, сум, баг, хорооны Засаг дарга, харьяа сум, баг, хороо, сургуулийн нийгмийн ажилтан, эсхүл хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа ажилтантай хамтран хэрэгжүүлнэ.

13.1.2 Тусгаарлах арга хэмжээг авахын тулд хохирогч хүүхдийн нөхцөлд байдалд эрсдлийн үнэлгээ хийж гэр бүлийн орчинд эсвэл гэр бүлээс тусдаа орчинд хамгаалах талаар шийдвэр гаргана.

13.1.2.1 Эрсдлийн үнэлгээгээр хохирогч хүүхэд ураг төрлийн хүчингийн гэмт хэргийн хохирогч, эсхүл эрсдэлт нөхцөлд байдал байгаа бол хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлан түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд байрлуулах, эсхүл хохирогч хүүхдийг хамгаалах боломжтой хамаатан, төрөл садан, ойр дотны хүний хамгаалалтад түр өгөх арга хэмжээг авч болно.

13.1.3 Аюулгүй байдлын хамгаалалтад байгаа хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу төрийн зүгээс “хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ” эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий цогц үйл ажиллагааг зохион байгуулна

13.1.2 Хүүхдийг гэрээс нь авч явахаас илүү боломжтой бол сэжигтэн, хүчирхийлэл үйлдэгчийг орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран гэрээс нь холдуулах арга хэмжээ авах нь зохимжтой.

13.1.3 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг ямар ч тохиолдолд гэрт нь эсвэл хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийн байгаа болон тэрхүү этгээдийн очиж болохоор газар буцааж болохгүй.

13.1.4 Бэлгийн хүчирхийллийн тохиолдол илэрсэн/эсвэл мэдээлэгдснээс хойш хохирогч хүүхэд илүү эрсдэлтэй байдалд (гэр бүлийнхний нь зүгээс хохирогчийг буруутгах, гэмт этгээд нэр хүндийг нь гутаах мэдээ, мэдээлэл тараах, сүрдүүлэх зэрэг) ордог тул аюулгүй байдлын хамгаалалтын үед дээрх эрсдлээс урьдчилан сэргийлэхэд анхаарна.

13.1.5 Хүчирхийллийн тохиолдол илэрсний дараа хүүхэд сэтгэл зүйн хувь дахин цочрохын хамт гэр бүл, найз нөхөд, ойр дотныхон, нийгмийн зүгээс үзүүлэх дарамтанд өртөх эрсдэлтэй тул сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд заавал хамруулна.

13.1.6 Хохирогч хүүхдийг аюулгүй газар түр байрлуулахдаа MNS 6040:2019 стандартын шаардлагыг¹⁸ хангасан түр хамгаалах байранд байрлуулна.

13.1.7 Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг байрлуулахдаа хүүхдийн нас, хөгжлийн түвшин, эрүүл мэнд, сэтгэл зүйн байр байдлыг харгалзан шаардлагатай тохиолдолд бусад хүүхдээс тусад нь байлгана.

13.1.8 Хүүхдийг бие, сэтгэлийн шархаа эдгээхэд шаардлагатай цаг хугацаагаар амрааж, сэтгэлийг тайван байлгах нөхцлөөр хангана.

13.1.9 Түр хамгаалах байр, асралт гэр бүлийн гишүүдийг хохирогч хүүхдээс бэлгийн хүчирхийллийн тохиолдлын талаар дахин асуух, шалгаах, үл итгэх болон буруутгах хандлага гаргах зэрэг хүүхдэд хоёрдогч хохирол учруулж болох аливаа үг, үйлдэл, хандлага гаргахгүй байхад анхаарах талаар хэлж, арга зүйн зөвлөгөө өгнө.

13.1.10 Хүүхдийг түр хамгаалалтад байх хугацаанд бусад хүүхэдтэй тоглох, хөгжим сонсох, өөрийн дуртай зүйлийг хийх зэргээр цагийг хөгжилтэй өнгөрөөх боломж нөхцлөөр хангана. Ингэснээр тэднийг ганцаараа байж, өөр тохиолдсон үйл явдлыг дахин дахин бодож зовж шаналахаас сэргийлж, биеийн ба сэтгэлийн шарх эдгэрэх үйл явцыг хурдасгадаг.

¹⁷ Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 6-р зүйлд зааснаар хамгаалалтын арга хэмжээ нь аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ ба сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ гэсэн хоёр төрөлтэй байна.

¹⁸ MNS 6040:2019 Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

13.1.11 Хүүхэд гэртээ байх тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийг амрааж тайван байлгахын чухлыг ойлгуулж, хүүхдэд цаг зав гаргаж, тэдэнтэй тоглох, ярилцах зэргээр цагийг хамт өнгөрөөж, аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлэх талаар арга зүйн зөвлөгөө өгнө.

14

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх

14.1 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг¹⁹ мэргэшсэн²⁰ эмч, эмнэлгийн ажилтан нэг дор, төвлөрсөн байдлаар үзүүлнэ.

14.2 Хүүхдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлж буй мэргэшсэн эмч нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлийн шинж тэмдгийг ажиглах, олж тогтоох, оношлох, эдгээх, шаардлагатай тусламж үйлчилгээнд холбох мэдлэг, хандлага, ур чадвартай байна.

14.3 Хохирогч хүүхдэд илэрч буй анхаарал татахуйц ямар нэг шинж тэмдэг олж илрүүлсэн тохиолдолд болзошгүй хүчирхийллийн талаар хүүхдийн насанд тохирсон, хүүхдэд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй асуултуудыг асууж ярилцах замаар хүүхдийн эсрэг үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийг тогтоож болно.

14.4 Хохирогч хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үйлчилгээний бусад орчноос тусгаарлагдсан орчинд үзүүлнэ.

14.5 Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн тухай тэмдэглэлийг эмнэлгийн бүртгэлд бүртгэхдээ хүүхдийн нэр төр, хувийн нууцыг хамгаалахад анхаарна.

14.6 Хүүхдэд эмнэлгийн үзлэг, шинжилгээ хийх болон мэдээллийг мэдэх шаардлагатай гуравдагч этгээдэд дамжуулах тухай таниулсан зөвшөөрлийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчаас авна.

14.7 Бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон эсвэл болзошгүй эрсдэлд байгаа хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ эмч мэргэжилтнүүд хүүхдэд дахин гэмтэл, хор хохирол, сэтгэл зүйн айдас түгшүүр, таагүй байдал үүсгэхээс урьдчилан сэргийлж, хүүхдийн бие даасан, халдашгүй байдлыг хүндэтгэн үзэж, хүүхдийн хүсэл сонирхлыг анхаарна.

14.9 Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний үед хүүхдийн дэргэд эцэг эх, эх, асран хамгаалагч (хүүхэдтэй эрх ашгийн зөрчилгүй тохиолдолд) хууль ёсны төлөөлөгчийг байлцуулна.

14.10 Тусламж дэмжлэгийн орчин, арга хэлбэрийг хүүхдийн насанд тохирсон байдлаар түүнчлэн хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг хандлагын улмаас ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэлтэй үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн байдлаар зохион байгуулж хүргэнэ.

14.11 Эмч, мэргэжилтний зүгээс хүүхдэд үзлэг хийх, эмнэлгийн тусламж үзүүлэх үедээ бэлгийн хүчирхийлэлд өртснөөс үүдэлтэй өвчлөл, бэртэл, гэмтэл, халдвар, жирэмслэлтийн тохиолдол байгаа эсэхийг нарийвчлан шинжилж эмчийн дүгнэлт гаргана. Үүнд:

- бэлгийн замаар дамжих халдвар авсан эсэх;
- бэлэг эрхтэн, нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоонд бэртэл гэмтэл учирсан эсэх;
- жирэмслэлт, зулбалт, үр хөндөлтийн шинж тэмдэг байгаа эсэх.

14.12 Хохирогч хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсний улмаас жирэмсэн болсон тохиолдолд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- хуульд заасны дагуу аюулгүй үр хөндөлт хийх боломжийн тухай хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагчтэй зөвлөлдөн шийдвэрлэнэ.

¹⁹ Эрүүл мэндийн тухай хуулийн 13.4. дэх заалт: Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь өрхийн эрүүл мэндийн, эмнэлгийн мэргэшсэн, эх барихын, эмнэлгийн яаралтай, сувилахуйн дагнасан, түргэн тусламжийн, сэргээн засахын гэсэн төрөлтэй байна.

²⁰ Бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах талаар 32 цагийн сургалтанд хамрагдсан байх

- Хэрвээ үр хөндөлт хийхэд оройтсон бол хүүхдийг ургийг тээн төрүүлэх хугацаанд жирэмсний үеийн тусламж үйлчилгээг хуулийн дагуу үзүүлнэ.
- Төрсний дараа хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлыг хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчтай зөвлөлдөн хуулийн дагуу шийдвэрлэнэ.

14.13 Хүүхдийн эрүүл мэндийн нөхцөл байдлын тухай мэдээллийг хүүхдэд өөрт нь ба эцэг эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгч, хүүхэд хамгааллын ажилтан ба цагдаагийн байгууллагын албан хаагчид өгнө. Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч эрх ашгийн сонирхлын зөрчилтэй бол хүүхдэд хийсэн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээллийг өгөхийг хориглоно.

14.14 Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэд учирсан бэртэл, гэмтэл, халдвар, жирэмслэлт зэрэг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, оношилгооны үр дүн, эмчийн дүгнэлтийг сайтар тайлбарлаж, асуусан асуултанд бүрэн дүүрэн дэлгэрэнгүй хариулт өгнө.

14.15 Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, оношилгооны үр дүнд үндэслэн шаардлагатай тохиолдолд өвчин зовиурыг багасгахад чиглэсэн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

14.16 Бэлгийн хүчирхийллийн улмаас хүүхдийн эрүүл мэндэд учирсан хор хохирол, өвчин зовиур, бэртэл гэмтэл, халдварыг эмчлэх зорилгоор эмчилгээг төлөвлөн үзүүлж, эмчилгээний чанар, үр дүнд хяналт тавина.

14.17 Шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмчийн тусламж, үйлчилгээнд холбон зуучилна. Холбон зуучлах үйлчилгээг зохих журмын дагуу үзүүлнэ.

14.18

Хориглох зүйл

14.18.1 Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үед хийх шаардлагагүй буюу хүүхдэд нэмэлт дарамт, таагүй байдал үүсгэж болзошгүй тул эмэгтэй хүүхдийн онгон хальс цоорсон эсэхийг шалгах үзлэгийг хийх шаардлагагүй.

14.18.2 Хүүхдэд эмнэлгийн тусламж үзүүлэх явцад нотлох баримтын зорилгоор авсан хүүхдийн бие дээрх хөхрөлт няцралтын зураг, бичлэг зэргийг хувийн гар утас, зургийн камерт хадгалахыг хориглоно.

14.19 Эмнэлгийн яаралтай болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлж буй эмч, эмнэлгийн ажилтан хүйсийн мэдрэмжтэй, хүүхэд, өсвөр үеийнхний онцлогийг харгалзан хохирогч төвт тусламж үйлчилгээ үзүүлнэ. Эмнэлгийн тусламж үзүүлэх үед хүүхэдтэй харилцах удирдамж (С хавсралт)

14.19.1 Хүүхдийн болон эцэг эх, асран хамгаалагчийн өгч буй мэдээллийг анхааралтай, хүндэтгэлтэй, ойлгож сонсох;

14.19.2 Хүүхэд, өсвөр үеийнхний санаа зовж буй зүйлийн талаар асууж тодруулах, асуусан бүх асуултанд хариулах;

14.19.3 Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийг үл буруутгасан байдлаар хандах;

14.19.4 Нийгэм сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдахыг санал болгож, хүүхдэд сэтгэл зүйн дэмжлэг болон бусад тусламж дэмжлэгийг үзүүлэх;

14.19.5 Хүүхдэд үзүүлэх дэмжлэг үйлчилгээний талаар насанд тохирсон байдлаар мэдээлэх, тухайлбал тэдний хүчирхийлэлд өртсөн тухай бусад холбогдох ажилтан, мэргэжилтнүүдэд мэдээлэх эсэх гэх мэт

15

Сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээ үзүүлэх

15.1 Сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээг мэргэшсэн, хүүхэдтэй харилцах чадвар эзэмшсэн, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд илрэх онцлогийн талаар сургалтанд хамрагдсан мэргэшсэн сэтгэл зүйч үзүүлнэ.

15.2 Хохирогч хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

15.3 Хүчирхийлэлд өртсний улмаас бий болсон шинж тэмдгүүд тухайн хүүхдийн хувийн онцлогоос шалтгаалан өөр өөр байж болохыг харгалзан, хүчирхийллийн шинж тэмдэг тухайн үйл явдал болж өнгөрснөөс хойш 48-аас 72 цагийн дараа багасч, 30 хоногийн дараа намжмал байдалд шилждэг тул сэтгэл зүйч энэ байдлыг харгалзан үзнэ.

15.4 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэл зүйн байдалд үнэлгээ хийхдээ хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон, практикт туршигдсан, сэтгэц хэмжил зүйн үнэлгээ хийгдсэн үнэлгээний арга хэрэгслийг (хурдавчилсан асуумж) ашиглана.

15.5 Сэтгэл зүйч нь бэлгийн хүчирхийллийн хохирогч/хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд, хүчирхийлэлд өртснөөс үүдэлтэй сэтгэцийн гэмтлийн байдлыг судлан тодорхойлно. Үүнд:

15.5.1 Хохирогч/даван туулагч хүүхдийн сэтгэцийн үйл ажиллагааны онцлог, тэдэнд илрэх сэтгэл зүйн ба бие махбодын шинжүүд, бэлгийн хүчирхийлэлд өртсний сөрөг үр дагаварыг үнэлэх

15.5.2 Хүчирхийлэлд өртснөөс үүдэлтэй хүүхдэд тохиолдсон сэтгэцийн гэмтлийг (trauma) тодорхойлох

15.5.3 Хохирогч хүүхдэд илэрч буй эрсдэлтэй зан үйлийг (архи, тамхинд донтох, замбараагүй бэлгийн харилцаа гэх мэт) тодорхойлох

15.5.4 Хүчирхийлэлд өртсний улмаас хүүхдэд зонхилон тохиолдох сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүдийг судлан тодорхойлох

15.6 Сэтгэл зүйч нь хохирогч/даван туулагч хүүхдэд тулгарч буй сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд, сэтгэцийн гэмтэлд чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээг тодорхой арга техникийн дагуу үзүүлнэ. Тухайлбал: Танин мэдэхүй, зан үйлийн зөвлөгөө засал, аажмаар нуур тулах засал, хямралыг зохицуулах гэх мэт

15.7 Сэтгэл зүйч нь бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхдэд илэрч буй цочмог хариу урвалын шинжүүд, айдас, түгшүүрийг намжаах, хүчирхийллийн дурсамжаа гадагшлуулах, тайвшруулах, булчин суллах, стресс тайлах энгийн аргуудыг хүүхдийн нас, хөгжлийн түвшин, тусгай хэрэгцээнд тохируулан зөвлөж, дадлагажуулсан байна.

15.8 Сэтгэл зүйч нь хохирогч/даван туулагч хүүхдийн хүчирхийллийг даван туулах үе шатны шинж тэмдгүүдийг ажиглаж, хүүхэд, эцэг эх асран хамгаалагчид энэ талаар тайлбарлаж өгнө.

15.9 Хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө тусламж үзүүлэхдээ хүүхдийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухайн хүүхдийн итгэл үнэмшил, хандлагад анхаарал хандуулах хэрэгтэй. Ялангуяа эрэгтэй хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хүүхдийн итгэл үнэмшил, хандлага маш чухал байдаг. Нийгмийн гутаан доромжлол, ижил хүйстэн гэж нэрлэгдэхээс айх айдас нь хүүхдэд хор хөнөөлтэй итгэл үнэмшлийг бий болгодог. Хор хөнөөлтэй итгэл үнэмшил нь хүүхэд хүчирхийлэлд өртсөнөө илчлэх хүсэлд нөлөөлж, цаашлаад сэтгэл зүйн хохирол учруулж болзошгүй.

15.10 Анхан шатны сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн хохирогч хүүхдийн бие сэтгэцийн байдалд дараах ноцтой шинж тэмдэг илэрч буй тохиолдолд дараагийн шатны буюу сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэн даруй холбон зуучилна.

15.10.1 Амиа хорлох эрсдэлтэй

15.10.2 Нийгэмд болон өөртөө аюултай үйлдэл хийх эрсдэл бүхий сэтгэцийн байдалтай

15.10.3 Ухамсарт ухаан балартал (Цаг хугацаа, орон зай, өөрийн баримжаа буурсан буюу алдагдсан байх)

15.10.4 Сэтгэцийн бусад эмгэг (Солиорлын шинж тэмдэг, сэтгэл гутралын хүнд хэлбэр гэх мэт бусад)

15.11 Хүүхдэд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж буй сэтгэл зүйч нь шаардлагатай тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа болон шүүх хуралдааны явцад гэрчээр оролцох, хохирогч хүүхэд учирсан сэтгэл зүйн гэмтэл хохирлыг нотлох баримтаар хангах зэргээр оролцож болзошгүй тул хүүхдийн сэтгэл зүйн байдалд өгсөн үнэлгээ, оношилгоог зохих ёсоор баримтжуулсан, нууцлалыг сайтар хангасан орчинд хадгалахын хамт хууль, журамд заасны дагуу гуравдагч этгээдтэй хуваалцана.

15.12 Хохирогч хүүхдийн түүх, түүний ярьсан мэдээлэл, зурсан зураг зэрэг сэтгэл зүйн тусламж үйлчилгээний явцад олж авсан мэдээ, мэдээллийг сургалт, судалгааны зорилгоор ашиглах, олон нийтэд мэдээлэх шаардлага гарвал хүүхдийн хувийн нууцыг хадгалахын хамт мэргэжлийн ёс зүйг баримтлан, хохирогч хүүхдийг таних боломжгүй болгож, хүүхэд эцэг эх, асран хамгаалагч ба мэргэжлийн байгууллагын зөвшөөрлийг авсан байна.

15.13 Хохирогч хүүхдэд үзүүлж буй сэтгэл зүйн тусламж үйлчилгээний явц, үр дүнгийн талаар мэдээллийг хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдтэй хуваалцаж, хүүхдийн эрх, ашиг сонирхлын төлөө сэтгэл зүйн тусламж үйлчилгээний явцад олж мэдсэн чухал мэдээлэл, баримт нотолгоог хамтарсан багийн уулзалтын үеэр гишүүдэд танилцуулж, хүүхэд хамгааллын кейс төлөвлөгөөнд тусгуулна.

15.14 Хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх явцдаа сэтгэл зүйч дам байдлаар гэмтэх эрсдэлтэй байдаг тул мэргэжил нэгт сэтгэл зүйч болон ахлах сэтгэл зүйчтэй уулзаж зөвлөгөө авах, мэргэжлийн стресс, дам гэмтлээс сэргийлэх арга зүйн сургалтанд хамрагдах зэргээр өөрийн сэтгэл зүйн байдалд тогтмол анхаарна. Энэ үед хохирогч хүүхдийн хувийн мэдээллийг алдах эрсдэлтэй тул анхаарал болгоомжтой байна.

16

Хууль, эрх зүйн туслалцаа²¹

16.1 Насанд хүрээгүй хохирогч хүүхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчоор оролцохоор цагдаагийн байгууллагад хамгаалалтад орох хүсэлт гаргах тохиолдолд хохирогч хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг холбогдох хуулийн хүрээнд арга хэмжээ авахад эрх зүйн туслалцаа үзүүлнэ.

16.2 Хохирогч хүүхдэд эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлнэ.²²

16.3 Хууль эрх зүйн туслалцааг мэргэшсэн мэргэжилтнээр үзүүлнэ. Үүнд эрх зүйн зөвлөгөөг эрх зүйч, өмгөөллийн үйлчилгээг мэргэшсэн өмгөөлөгч үзүүлнэ.

16.4 Хууль эрх зүйн туслалцаа нь насанд хүрээгүй хохирогчийн танин мэдэхүйн түвшинд тохирсон байна.

16.5 Хөгжлийн бэрхшээлтэй хохирогч хүүхдэд хууль эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ түүний эрх үүрэг болон холбогдох мэдээллийг тусгай хэрэгцээнд нийцүүлэн ойлгомжтой, хүртээмжтэй арга хэлбэрээр хүргэнэ.

16.6 Хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх мэргэжилтэн нь бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах чиглэлээр мэргэшсэн байна.

16.6.1 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цагдаагийн байгууллага хүүхдээс мэдүүлэг авах, уулзах болон шүүх хуралдааны үед хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийг бэлтгэж, шаардлагатай хууль эрх зүйн мэдлэг мэдээллээр хангана.

²¹ Хохирогч хүүхдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа нь эрх зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээнээс бүрдэнэ.

²² Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль, 6-р зүйл. Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах хүн

16.6.2 Ураг төрлийн бэлгийн хүчирхийллийн үед хүчирхийлэл үйлдэгч, түүнтэй холбоотой хүмүүсийн дарамт шахалтын улмаас хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг үгүйсгэх, цагдаад өгсөн гомдол, мэдээллээ татан авах зэргээр хүүхдийн эрх ашгийг хохироосон үйлдэл гарвал хүүхдийн эрх, ашгийг хамгаалан ажиллана.

16.6.4 Томилогдсон өмгөөлөгч нь Хххирогч хүүхдийн бие махбод, сэтгэл зүйд учирсан хохирол, хор уршгийг тогтоох, хохирол нэхэмжлэх эрхийг хангах чиглэлээр хариуцлагатай ажиллана. Үүнд:

16.6.4.1 хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалгуулах, шаардлагатай эд зүйл, баримт сэлтийг цуглуулах,

16.6.4.2 лавлагаа, тодорхойлолт, баримт сэлтийг гаргуулахаар тухайн асуудлыг хариуцсан төр, төрийн бус байгууллагад хүсэлт гаргах,

16.6.4.3 нотлох баримт гаргаж өгөх, шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах,

16.6.4.4 үйлчлүүлэгч хүүхдийг аль ч байгууллагад төлөөлөх,

16.6.4.5 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусад оролцогчид асуулт тавьж хариулт авах зэргээр идэвхтэй оролцох

16.6.5 Хохирогч хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц, хууль тогтоомжийн агуулга, түүний хууль зүйн үр дагаврыг тайлбарлаж, мэдээллийг цаг алдалгүй өгөх, шүүх хуралдаанд үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн мэдээлэл, судалгаа бэлтгэлтэй оролцох үүрэг хүлээнэ.

16.6.6 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, цагдаагийн байгууллага хүүхдийн эрхэд суурилсан, хохирогч төвтэй арга зүйгээр холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу ажиллаж буй эсэхэд хяналт тавьж зөрчигдвөл шаардлага хүргүүлнэ.

16.7

Хориглох зүйл

Хууль зүйн туслалцаа үзүүлж буй мэргэжилтэн хүчирхийлэл үйлдэгч талын нөлөөнд автаж, хүүхдийн өгсөн мэдээллийн нууцлалыг задлах, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэргээр хүүхдийн эрх ашиг, сонирхлын эсрэг ажиллахыг хориглоно.

17

Боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах нь

17.1 Хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлж буй байгууллага мэргэжилтэн нь үйлчилгээ үзүүлэх явцдаа хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах арга хэмжээ авна.

17.1.1 Хохирогч хүүхдийг түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, асралт гэр бүлийн харьяаллын сургуульд суралцуулах талаар сургуулийн захирал, сургалтын менежертэй уулзаж, сургалтын арга хэлбэр, суралцах анги, түвшинг тодорхойлно.

17.1.2 Хүүхдийг сургуульд аюулгүй хүргэх, авах ажлыг зохион байгуулна.

17.2 Хохирогч хүүхэд жирэмсэн, төрсөн, хөхүүл тохиолдолд хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчтай зөвшилцөн хүүхдэд тохиромжтой арга хэлбэрээр сургалтыг зохион байгуулна.

17.3 Хохирогч хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртсөн, жирэмсэн, хүүхэд төрүүлсэн, хөхүүл шалтгаанаар сургуульд элсүүлэх, үргэлжлүүлэн суралцуулахаас татгалзахыг хориглоно.

17.4 Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд сургуульд үргэлжүүлэн суралцах тохиолдолд хүүхдийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаарх мэдээллийг хүүхдийн анги хамт олон, ангийн багш, бусад багш ажилтнуудаас чандлан нууцлана.

17.5 Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн талаар илрүүлэх, мэдээлэх үйл явцад тухайн хүүхдийн мэдээллийг олж мэдсэн сургуулийн багш, ажилтнуудтай сургуулийн хүүхэд хамгааллын багийн ахлагч болох сургуулийн захирал нууцын гэрээ байгуулж, хүүхдийн хувийн мэдээллийг чандлан хадгалах үүрэг хүлээсэн тухай сануулж, мэдээллийг задалсан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээх тухай сануулна.

17.6 Хохирогч хүүхдийн хүчирхийлэлд өртсөн тухай мэдээллийг сургуулийн ба бусад орчинд тараасан багш, ажилтнуудад хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

18.

Нийгмийн халамжийн үйлчилгээ

18.1 Хохирогч хүүхдийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болох зөвлөгөө өгөх, сэргээн засах үйлчилгээ, түр байрлан асрамжийн болон хамгаалан байрлуулах үйлчилгээ, өдрийн үйлчилгээ, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ, иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээнд хамруулна.

18.2. Шаардлагатай тохиолдолд хохирогч хүүхдийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээ болон асрамжийн хувилбарт үйлчилгээнд хамруулна.

19

Эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлтэй ажиллах

19.1 Кейс менежерийн зүгээс хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид бэлгийн хүчирхийллийн талаар мэдлэг олгож, арга зүйн зөвлөгөө өгнө.

19.2 Эцэг эх, асран хамгаалагч нь уурлах, ичих, харамсах, гэмших гэх мэт сэтгэл зүйн хямралд өртсөн тохиолдолд сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулна.

19.3 Хүүхдэд нь тохиолдсон бэлгийн хүчирхийлэл ямар үйл явцыг дамжин, хэрхэн өрнөсөн тухай тайлбарлана.

19.4 Хүүхдээ буруутгахгүй байхын ач холбогдлыг ойлгуулж, хүүхдэд хоёрдогч хохирол учрахаас урьдчилан сэргийлнэ.

19.5 Хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйл, сэтгэцийн эрүүл мэндийн байдлын тухай, хүүхдэд илэрч болох гэмтлийн дараах стрессийн хам шинж, сэтгэл гутрал, айдас түгшүүрийн тухай ойлгуулж, ийм үед хүүхдээ хэрхэн дэмжлэг үзүүлж, үр дүнтэй харилцах талаар заавар зөвлөгөө өгнө.

19.6 Хүүхэд амиа хорлох, өөрийгөө гэмтээх зан үйл гаргах эрсдэлтэй, хямралд өртсөн тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчид зөвлөгөө өгч, хүүхэдтэйгээ хэрхэн үр дүнтэй харилцаж сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх талаар зөвлөгөө өгнө.

19.7 Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хүүхдээ нас, хөгжлийн онцлогт тохирсон үйл ажиллагаанд татан оролцуулах, хүүхдийн өдөр тутмын амьдралыг хэвийн (тогтмол цагт унтуулах, тэжээллэг хоол хүнсээр хангах гэх мэт) үргэлжлүүлэх талаар зөвлөж хамтарч ажиллана.

19.8 Хүүхдэд хийж буй эмчилгээний зааврыг дагаж мөрдөх, хүүхдээ эмчлүүлэхэд нь тусалж дэмжих талаар зөвлөн тусална.

19.9 Хүчирхийлэл үйлдэгч этгээдэд шийтгэл оногдуулах тал дээр хэтэрхий анхаарч хүүхдээ үл хайхарч буй эсвэл хүүхдээ хүчирхийлэлд өртсөнд өөрсдийгөө буруутгаж буй зэрэг сэтгэл зүйн тулгамдсан асуудал бүхий эцэг эх, асран хамгаалагчдыг сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд хамруулна.

Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үеийн хүүхэд хамгаалал

18.1

Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, зохистой ашиглах²³

Цагдаагийн байгууллагад²⁴ хүүхдэд ээлтэй орчинг барилгын үндсэн орц, гарц, үүдний танхимаас зайдуу, дамждаггүй, тусгайлсан хаалгатай, дуу чимээ багатай газарт буюу аль болох тусад нь байгуулна.

- Халаалттай, дулаахан
- Цонхоор байгалийн гэрэл хангалттай орохуйц, онгойлгож агаар сэлгэх боломжтой байх;
- Хүүхдэд ээлтэй, албан бус, тав тухыг мэдрүүлэх тавилгаар тохижуулах, үүнд 2-оос 3 хүний тусдаа буйдан, ширээ, зөөлөн сандал, шүүгээ, номын тавиур, тоглоомын булан, мэдээллийн булантай байх;
- Бие засах газар, угаалтууртай байх;
- Цай хоолны хэрэгсэлтэй байх;
- Цэвэр ус уух боломжтой байх;
- Хүүхдээс ярилцлага, мэдүүлэг авах зориулалттай дууны, дүрсний, дуу дүрс бичлэг хийх төхөөрөмжөөр тоноглогдсон байх;
- Хүүхэд хамгаалал, эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль эрх зүйн ба бусад үйлчилгээ, туслалцаа дэмжлэгийн талаарх мэдээлэл танилцуулгыг хүүхдэд ойлгомжтой байдлаар бэлтгэсэн байх;
- Хүүхдэд ээлтэй орон зайг зориулалтын дагуу ашигладаг байх.

18.2 Хүүхдэд ээлтэй орон зайг хүүхдээс ярилцлага, мэдүүлэг авах, тэдэнд сэтгэл зүйн, хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх үед ашиглана.

18.3 Хүүхдэд ээлтэй ерөөний ашиглалт, ариутгал цэвэрлэгээг хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцан гүйцэтгүүлж, хяналт тавина.

18.4 Хүүхдэд ээлтэй орон зай, ерөөний ашиглалтын бүртгэл хөтөлнө.

19

Хууль ёсны төлөөлөгч томилох нь

19.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад насанд хүрээгүй хохирогч хүүхдэд хууль ёсны төлөөлөгчийг томилсон байна.

19.2 Хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр төрсөн, үрчилж авсан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилох ба тухайн этгээд нь байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтооно.

19.3 Хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон төрийн байгууллагын албан хаагч/мэргэжилтэн нь хүүхдийн эрх ашгийг төлөөлөх үүрэг хариуцлагаа ухамсарлаж, хүүхдийн эрх ашгийг хамгаалахын төлөө хариуцлагатай ажиллана.

19.3.1 Хүүхдэд тохиолдсон бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих;

19.3.2 Бэлгийн хүчирхийллийн улмаас хүүхдэд учирсан хор хохирлыг нэхэмжлэх;

²³ Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд боловсруулсан Цагдаагийн байгууллагад хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зөвлөмжийн “Орчин ба дэд бүтэц” хэсгээс тохируулан авав.

²⁴ Аймаг, дүүргийн цагдаагийн хэлтэс

19.3 Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага нь бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон мэргэжилтнийг тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд тогтвортой ажиллах бүх бололцоогоор хангана.

20

Хохирогч хүүхдээс мэдүүлэг авах

20.1 Хохирогч хүүхдийг цагдаагийн байгууллагад байх хугацаанд хүүхдэд ээлтэй орчинд байлгана.

20.2 Бэлгийн хүчирхийллийн хохирогч, гэрч хүүхдээс тайлбар, мэдүүлэг авах ажиллагааг хүүхдийн байгаа газар, эсвэл хүүхдэд ээлтэй орчин бүхий тусгай өрөөнд зохион байгуулах арга хэмжээг авна.²⁵

20.3 Хүүхэд хүсэхгүй тохиолдолд мэдүүлгийг өгөхийг албадахгүй.

20.4 Мэдүүлэг авахаас өмнө өмгөөлөгч, сэтгэл зүйч оролцуулах замаар хүүхдэд чөлөөтэй ярих, ээлтэй уур амьсгалыг бүрдүүлнэ.

20.5 Мэдүүлэг, уулзалтын өмнө хүүхдийг зохих ёсоор бэлтгэх, үүнд хэзээ хаана болох, хэн оролцох, хүүхдийн үзэл бодлыг хэрхэн авч үзэх талаар тодорхой мэдээлэл өгнө.

20.6 Хүүхдээс мэдүүлэг авахын өмнө түүнд хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн чухлыг дараах байдлаар тайлбарлана. Үүнд:

20.6.1 Мэдэхгүй байгаа талаарх зааварчилгаа – хэрвээ хүүхэд хариултыг сайн мэдэхгүй байгаа бол таамаглаж хариулснаас илүү би мэдэхгүй гэдгээ хэлэх;

20.6.2 Ойлгохгүй байгаа талаарх зааварчилгаа – мэргэжилтний ярьж буй зүйлийг ойлгохгүй байгаа хүүхэд таах гэж оролдохгүйгээр ойлгохгүй байгаагаа нээлттэй хэлэх;

20.6.3 Миний буруутай талаарх зааварчилгаа – мэргэжилтэн ямар нэг зүйлийг буруу хэлбэл хүүхэд засч өгвөл сайн гэдгийг хэлэх.

20.7 Мэдүүлэг авахад ашиг сонирхлын зөрчилгүй асран хамгаалагч, эсвэл хүүхдийн хууль ёсны төлөөлөгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг байлцуулж, өмгөөлөгчийг оролцуулна. Хүүхдийн эрх ашиг зөрчигдөх бодит үндэслэл байвал асран хамгаалагч, эсвэл хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийг оролцуулахгүй байж болно.

20.7.1. Хүүхэд мэдүүлэг өгөх бүрт бичлэг хийж хадгална.

20.7.2. Мэдүүлэг авах үед эцэг эх, асран хамгаалагч, бусад этгээдийн зүгээс саад болохооргүй орчин нөхцлийг бүрдүүлнэ.

20.7.3. Мөрдөгчийн зөвшөөрснөөр хууль ёсны төлөөлөгч, сурган хүмүүжүүлэгч арван хүүхдээс асуултыг зөв ойлгосон эсэхийг тодруулан асууж, тайлбарлаж болно.

20.7.4. Мэдүүлэг авч дуусмагц мэдүүлэгт юу гэж бичсэнийг тайлбарлана. Хэрэв хүүхэд бичсэн зүйлтэй санал нийлэхгүй байгаа бол ямар өөлчлөлт хийх шаардлагатай байгаа тухай саналаа хэлж болно гэдгийг хүүхдэд ойлгуулна.

20.7.5. Хүүхдээс ямар ч тохиолдолд шөнийн цагаар мэдүүлэг авахыг хориглоно.

21

Хэргийг мөрдөн шалгах ажиллагааны үеийн хүүхэд хамгаалал

21.1 Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, мөрдөгч нь хүүхэдтэй уулзсан анхны уулзалтаас хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдыг (гэмт хэрэгт хамааралгүй тохиолдолд) шаардлагатай мэдээллээр хангана. Үүнд:

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хүүхдийн эрх, холбогдох дүрэм журам;
- Нууцлалын зарчим, хязгаарлалт буюу цуцлах нөхцөл;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар, үе шат;

²⁵ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 41.1.7

- Аюулгүй байдал, хамгаалалтын арга хэмжээ авах боломж;
- Хууль, эрх зүйн туслалцаа авах боломж;
- Эрүүл мэндийн, сэтгэл зүйн ба хүүхэд хамгааллын, орчуулгын зэрэг боломжит үйлчилгээний тухай.

21.2 Мэдээллийг хүүхдийн нас, хөгжлийн түвшин, хөгжлийн бэрхшээл ба хэлний бэрхшээлийг харгалзан тохируулан, ойлгомжтой, хүртээмжтэй арга хэлбэрээр хүргэнэ.

21.3 Эцэг эх, асран хамгаалагчид мэдээлснийг **10 ба түүнээс дээш** насны хүүхдэд мэдээлсэнд тооцож болохгүй.

21.4 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийн ямар ч хувийн мэдээлэл, өгөгдлийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргах, хэвлэн нийтлэхийг хориглоно. Үүнд:

- Хүүхдийн дуу, дүрсний бичлэг, зураг, өмссөн хувцас, тоглоом, эд зүйл;
- Хүүхдийн хувийн мэдээлэл: Хүүхэд, гэр бүлийн дэлгэрэнгүй мэдээлэл нэр гэрийн хаяг бүртгэлийн дугаар;
- Хүүхдийн эмзэг мэдээлэл;
- Хэргийн үйл явцын дэлгэрэнгүй мэдээлэл.

21.5 Олон нийтийн ашиг сонирхол, эрх зүйн боловсрол олгох, хүүхэд хамгааллын нөлөөллийн ажлын зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэргийн талаар мэдээлэх бол мэдээллийг хүүхдэд хамаатуулах боломжгүй болгох буюу хүүхдийг танигдах боломжгүй болгоно.

21.6 Хүүхдийн бүртгэл, гэмт хэргийн хавтас дахь хүүхдэд холбогдох мэдээллийг хадгалах, хэргийг хянан шийдвэрлэх явцад нотлох баримтын зорилгоор ашиглах, бусдад шилжүүлэх, архивлахдаа холбогдох журам, зааврыг дагаж мөрдөнө.

21.7 Цагдаагийн албан хаагчид мөрдөн шалгах ажиллагааны үед хохирогч хүүхдийг нас, хүйс, үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл, хэл шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, өмч хөрөнгө, хөгжлийн бэрхшээл болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахгүй, хүүхэд бүрт тэгш, шударга хандана.

21.8 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд эцэг, эх, гэр бүлийн гишүүд болон бусад этгээдийн дарамт, шахалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

21.8.1 Хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үйлдэгч нь эцэг эх, гэр бүлийн гишүүн буюу ойр дотны хүмүүс бол урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээг гэрч, хохирогчийг хамгаалах журмын дагуу авч хэрэгжүүлэн хүүхдийг хамгаалалтад авах;

21.8.2 Хүүхэд гэмт этгээд, түүний хамаарал бүхий этгээдтэй тааралдах эрсдлээс урьдчилан сэргийлэх;

21.8.3 Шүүх хуралдаанд цахимаар оролцуулах болон хүүхэдтэй хийсэн бичлэгийг үндэслэн хэргийг шийдэх талаар судлан хэрэгжүүлэх;

21.8.4 Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч хүүхэд өөрт тохиолдсон явдлын талаар олон дахин ярих, мэдүүлэг өгөхийг хязгаарлах, урьдчилан сэргийлэх.

21.9. Бэлгийн хүчирхийлэлд өртөж хохироход тэдний гэр бүлийн гишүүдийн үүрэг, оролцоо, тодорхой хэмжээнд байдаг тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулна.

22

Шүүх хуралдааны үеийн хамгаалал

22.1 Хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шүүх хуралдааныг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг хаалттай явуулна.

22.2 Хүүхдийн мэдүүлгийг дуу, дуу-дүрсний бичлэгээр урьдчилан баталгаажуулж авсан байх²⁶ ба шүүх хуралдааны үед хүүхдийг байлцуулахгүйгээр хэргийг хянан хэлэлцэхдээ тухайн бичлэгийн мэдээллийг үндэслэж болно.

22.3 Хохирогч хүүхдийн эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан зэрэг мэргэжилтэнтэй хийх ярилцлагын явцад өгсөн мэдээллийг баталгаажуулсан тэмдэглэл, бичлэгийг шүүхэд нотлох баримт болгон ашиглана.

22.4 Шүүх хуралдаанд хүүхэд гэрч, хохирогчоор оролцох үед:

22.4.1 Хүүхдийг ярихыг яаруулж болохгүй;

22.4.2 Хүүхдээс бэлгийн хүчирхийллийн үед болсон зүйлийг дэлгэрэнгүй ярих, дүрслэн үзүүлэхийг шаардаж болохгүй;

22.4.3 Шаардлагагүй үед хүүхдийн биед хүрч болохгүй.

23

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгах арга хэмжээ

23.1 Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас хүүхдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

23.2 Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирлыг нотлох баримтад дараах зүйлс багтах ба үүгээр хязгаарлагдахгүй.

23.2.1 Эмнэлгийн төлбөр;

23.2.2 Асаргаа, сувилгаа, нэмэгдэл хоолны зардал;

23.2.3 Эм, тарианы зардал;

23.2.4 Хиймэл эрхтэн хийлгэх зардал;

23.2.5 Утасны ярианы төлбөр;

23.2.6 Хохирогчийн урагдаж, гэмтсэн хувцасны үнэ;

23.2.7 Сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээний зардал;

23.2.8 Эмчилгээ хийлгэхээр явсан унааны зардал

23.3 Шүүхээс тогтоосон гэмт хэргийн хохирол, хор уршгийг арилгахад гарах зардлын мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хэмжээг нэхэмжлэлийг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.

23.4 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчоор нэхэмжлэлийг нь гаргуулан шийдвэрлүүлэх шаардлагатай.

24

Хамтарсан багийн ажиллагаа, салбар дундын зохицуулалт

24.1 Хохирогч хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчаас авсан мэдээлэл, ярилцлагын тэмдэглэлийг давхардуулан авахгүйгээр хүүхэд хамгааллын үйлчилгээ ба хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад цуглуулсан мэдээллийг салбар дундын хамтарсан баг ба холбогдох мэргэжилтнүүдийн хүрээнд хэрхэн хадгалж, хуваалцаж, архивлаж байхыг зохицуулсан салбар дундын дүрэм журам боловсруулан дагаж мөрдөнө.

25

Мэргэжилтэнд тавих нийтлэг шаардлага

25.1 Хохирогч хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүд бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй хэрхэн ажиллах талаар хамгийн багадаа 32 цагийн сургалтанд хамрагдсан байх;

25.2 Бэлгийн хүчирхийллийн мөн чанар, динамик, хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдэд илрэх шинж тэмдгийн талаар нарийн ойлголт, мэдлэгтэй, энэ тухай хүүхэд, эцэг эх, олон нийтэд мэдээлэл өгөх чадвартай байх;

²⁶ Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 41.1.2.

25.3 Хүүхдэд боловсрол, сургалтаар дамжуулан бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, өртсөн тохиолдолд хаана хэнд хэрхэн хандаж тусламж хүсэх талаар зөвлөх чадвартай байх;

25.4 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд өөрийн мэргэжлийн хүрээнд тусламж дэмжлэг үзүүлж, эцэг эх, олон нийт, гэр бүлийн гишүүдэд туслах чадвартай байх;

25.5 Хүүхдэд үр дүнтэй, цогц үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүүхдийн эрх, хамгааллын хууль тогтоомж, дүрэм журам, стандартын талаар мэдлэгтэй, тэдгээрийг практик хэрхэн хэрэгжүүлэх талаар дадлага, туршлагатай байх;

25.6 Хүүхдийн хөгжлийн үе шатны талаар мэдлэгтэй, хүүхэдтэй нас, сэтгэцийн хөгжлийн онцлогт тохируулан харилцах чадвартай байх;

25.7 Эмч, цагдаа, сэтгэл зүйч, хууль, өмгөөлөгч, багш, нийгмийн ажилтан зэрэг бусад мэргэжилтнүүдээс тусгай зөвлөгөө дэмжлэгийг хэрхэн авах, хэрхэн хамтарч ажиллах талаар мэдлэгтэй, бусад төрийн ба төрийн бус, ОУ-ын байгууллагатай хамтран ажиллах чадвартай байх;

25.8 Хүүхэдтэй ажиллах хохирогч төвтэй арга зүйг эзэмшсэн байх;

25.9 Хөвгүүд бэлгийн хүчирхийлэлд өртсөнтэй холбоотой тодорхой баримт, өвөрмөц асуудлыг мэддэг байх; Үүнд

25.9.1 хөвгүүд бэлгийн хүчирхийлэлд өртөж болно гэдгийг мэддэг байх,

25.9.2 хөвгүүд заавал эрэгтэй үйлчилгээ үзүүлэгчтэй ярихыг илүүд үзэхгүй байж болно,

25.9.3 ихэнх үйлчилгээ охидод түлхүү чиглэсэн байдгаас хөвгүүдэд тусламж хайх ижил төстэй боломжууд дутмаг байдаг.

25.9.4 хөвгүүдэд ч охидын адил аюулгүй байдлыг мэдрэх, халамжлуулах, итгэж, урамшуулах, тусламж хүсэх, бэлгийн хүчирхийллийн талаар мэдэх хэрэгцээ байдаг.

26

Хүүхэдтэй ажиллах мэргэжилтний хандлага, биеэ авч явах байдал

26.1 Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, мөрдөгч хүүхэдтэй ажиллах үедээ энгийн хувцастай байна.

26.2 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн шаардлагатай үед энгийн хувцас өмсөж болно.

26.3 Хүүхэд бэлгийн хүчирхийлэл өртсөнд хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч болон гэр бүлийг буруутгасан хандлага, үг үйлдэл гаргаж болохгүй.

26.4 Хүүхэдтэй харилцахдаа биеийн хэлэмж, дохио зангаа, нүдний хөдөлгөөн, хэл ярианы илэрхийлэл, ярианы өнгө аясыг анхаарч хүүхдэд хүндэтгэлтэй, эелдэг найрсаг харилцана.

26.5 Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийн хэлж ярьж буй зүйлийг анхааралтай сонсоно.

26.6 Хүүхдийг ямар ч байдлаар айлган сүрдүүлж, тав тухгүй байдал мэдрүүлэх үйлдэл үзүүлэхгүй.

26.7 Хүүхэдтэй харилцах үедээ болон хүүхдийн дэргэд тамхи, согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт болон бусад төрлийн бодис хэрэглэж болохгүй.

26.8 Хүүхэдтэй харилцах үедээ гар утсаараа оролдох, ярих зэргээр хүүхдийг үл тоомсорлож болохгүй.

26.9 Хүүхдийн хувийн орон зайг зөрчихгүй, хүүхдийн биед урьдчилан мэдэгдэхгүйгээр хүрэхгүй, бие махбодын болон сэтгэл зүйн ямар нэгэн зовиур дарамт учруулаж болохгүй.

26.10 Хүүхдийн дэргэд бусадтай түрэмгий харьцаж загнах зэргээр зохисгүй зан үйл гаргаж болохгүй.

26.11 Хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртснөө хүлээн зөвшөөрөх, бүгдийг ярихыг албадан шахахгүй.

26.12 Хүүхэд өлсөж цангаагүй, даарч ядраагүй эсэхэд анхаарч зохих арга хэмжээг авах

27

Бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхэдтэй ажиллах мэргэжилтнүүдэд байх шаардлагатай өвөрмөц итгэл үнэмшил

27.1 Хүүхдүүд бэлгийн хүчирхийллийн талаар үнэнийг хэлдэг.

27.2 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд буруу байхгүй.

27.3 Хүүхдүүд бэлгийн хүчирхийлэлд өртсөн ч даван туулж, эдгэрч чадна.

27.4 Хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж гутааж, доромжилж болохгүй.

27.5 Насанд хүрэгчид, түүний дотор эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийнхэн, үйлчилгээ үзүүлэгчид хүүхдийг буруутгахгүйгээр, шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлэх нь хүүхдийн эдгэрэлтэд чухал нөлөө үзүүлдэг.

27.6 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн ч хувийн нууцаа хамгаалуулах, халдашгүй дархан байдлаа хадгалах эрхтэй бөгөөд өөр тохиолдсон түүхийг хэнд, хэрхэн мэдээлэхээ шийдэх эрх, боломжоор хангагдах ёстой.

27.8 Хүүхэд ялангуяа том болсон өсвөр насны хүүхдүүдийг ч бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд бага насны хүүхдүүдэд тавьдаг шиг халамж анхаарал тавьж, аюулгүй байдлыг хангаж, хамгаалалтанд авах хэрэгтэй.

ТӨГСӨВ.

5 А хавсралт

6 Форензик ярилцлагын үе шат ба удирдамж

A1 Ярилцлагад бэлдэх

A1.1 Ярилцлагыг үр дүнтэй, амжилттай авахын тулд эцэг эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгч, мөрдөгч зэрэг субъектээс хүүхдийн талаар дараах үндсэн мэдээллийг цуглуулж танилцсан байна. Үүнд:

- Хүүхдийн нийгэм, хүн ам зүйн байдал; (нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, гэр бүлийн байдал, тусгай хэрэгцээ гэх мэт)
- Өмнө нь хүчирхийлэл дарамтад өртөж байсан тухай;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдаж байсан талаар;
- Хууль сахиулах үйл ажиллагаанд хамрагдаж байсан байдал;
- Эрүүл мэндийн түүх;
- Эмчийн үзлэгийн тэмдэглэл;
- Хүүхдийн сонирхол, хобби, суралцдаг сургууль, анги, найз нөхдийн холбоо;
- Хүүхэд ярилцлага хийх талаар ямар сэтгэгдэлтэй байгаа, үүсч болзошгүй хүндрэл.

A.1.2 Ярилцлага хийх орчин нөхцлийг бүрдүүлнэ. Хүүхэдтэй хийж буй ярилцлагыг, орчин нөхцлийг бичиж авах зориулалттай дууны, дүрсний, дуу дүрсний бичлэг хийх төхөөрөмжөөр тоноглогдсон орчин нөхцөлд явуулна.

A2

Танилцах ба холбоо тогтоох

Хүүхэдтэй танилцаж, итгэлцэл бүхий холбоо тогтооход анхаарна. Үүний тулд:

A2.1 Хүүхэдтэй ижил түвшинд сууж харилцана. Хэрвээ хүүхэд шалан дээр сууж байвал шалан дээр суух ба сандал дээр сууж байвал хажуугийн сандал дээр тохиромжтой зайнд сууна.

A2.2 Хүүхэдтэй мэндэлж, түүнд өөрийнхөө нэрийг хэлэх ба хүүхдээс нэрийг нь асууна.

A2.3 Бага насны хүүхэдтэй холбоо тогтоохын тулд тоглоом, наадгай (хүүхэлдэй, эвлүүлдэг тоглоом, зурагтай ном, буддаг ном гэх мэт) г ашиглана. Хүүхэдтэй хамт 5-10 минут орчим тоглоно. Чи юу хийж байгаа юм бэ? Энэ хүүхэлдэй юу хийж байгаа юм бэ? Чиний зурж/будаж буй зургийг харж болох уу? гэх зэрэг асуулт асуух замаар хүүхэдтэй харилцахыг хичээнэ.

A2.4 Хүүхэдтэй энгийн сэдвээр хэдэн минут харилцахыг хичээнэ. (Энэ нь хүүхдийн хөгжлийн түвшин, харилцааны чадвар ба сэтгэл хөдлөлийн байдлын талаар олж мэдэхэд тусална.) Чи өнөөдөр өглөөний цайндаа юу идсэн бэ? Өнөөдөр энд юугаар ирсэн бэ? Хэнтэй хамт ирсэн бэ? Гэх зэрэг энгийн асуултыг асууж ярилцана.

A2.5 Сургуулийн насны ба өсвөр насны хүүхэдтэй холбоо тогтоохдоо “Би чиний тухай илүү сайн мэдмээр байна. Чи өөрийнхөө хийх дуртай зүйлийнхээ тухай надад ярьж өгч болох уу?” гэж хэлж болно.

A3

Мэдээлэл өгөх

A3.1 Хүүхдэд тухайн орчны талаар болон хүүхдийг энд байлгаж байгаа зорилгын талаар танилцуулна.

Жишээ: “Миний нэрийг гэдэг бөгөөд миний ажил бол хүүхдүүд аюулгүй байгаа эсэх, хэн нэгэн тэднийг өвтгөж зовоогоогүй гэдгийг мэдэх явдал юм. Хэрвээ хэн нэгэн хүн хүүхдийг өвтгөж зовоосон бол бид хүүхдийг хамгаалалтад авч, түүнд тусладаг.

Чи энэ газрыг олон өрөө, тасалгаатай, олон хүнтэй байгааг харсан байх. Тэгэхээр энд чам шиг хүүхдүүд, хүмүүс ирж өөрийг нь өвтгөж зовоосон үйл явдал, хүний тухай ярьдаг юм. Тэр бүх хүүхдүүдэд туслахын тулд энд над шиг олон хүн ажилладаг юм шүү дээ.

Чи энэ газрыг сайн мэдэхгүй ч энд чи ямар ч аюулгүй. Энд бид хэсэг хугацаанд ярилцсны дараа чи буцаад гэртээ, ээж аавдаа очно.

A3.2 Хэрвээ дуу, дүрсний бичлэгийн төхөөрөмж, чихэвч зэрэг техник хэрэгсэл ашиглаж байгаа бол энэ тухай мэдээлж, яагаад хэрэглэж байгаа тухай тайлбарлана.

Жишээ: ... Чи харж байж магадгүй энд видео камер байна. Би бас чихэвч зүүсэн байгаа. Эдгээр нь хоёулангийн энд ярьсан яриаг бичиж авах болно. Ингэснээр би чиний хэлсэн зүйл бүрийг алдалгүй сонсох болно. Заримдаа би чиний хэлсэн зүйлийг мартчихаж магадгүй. Тэр үед бичлээг үзээд чамтай дахин ярихгүйгээр ярьсан зүйлийг чинь сэргээгээд мэдчихнэ гэсэн үг.

A3.3 Хэрвээ дэвтэрт тэмдэглэл хөтөлж байвал энэ тухай мөн хүүхдэд дээрх маягаар тайлбарлана.

A4

Зааварчилгаа өгөх

A4.1 Хүүхдэд зааварчилгаа өгснөөр тааж хариулах, ярилцлага авч буй хүний асуултыг аялдан дагалдах байдал үүсэхээс сэргийлж чадна.

A4.2 Ярилцлагын өмнө хүүхдэд дараах гурван зааварчилгааг өгнө.

- Мэдэхгүй байгаа талаарх зааварчилгаа: *Хэрэв миний асуултанд өгөх хариултаа мэдэхгүй байвал битгий тааж хариулаарай. Мэдэхгүй гэж хэлээрэй.*
- Ойлгохгүй байгаа талаарх зааварчилгаа: *Хэрэв миний юу асууж байгааг ойлгохгүй бол Би таны асуултыг ойлгохгүй байна гэж хариулаарай. Би асуултаа илүү ойлгомжтой асуух гэж хичээх болно.*
- Буруу асуулт асуусан талаарх зааварчилгаа: *Миний буруу бол хэлээрэй. Заримдаа би буруу ойлгоод буруу зүйл асууж магадгүй. Тэр үед намайг буруу ярьж байгааг буюу буруу асуулт асууж байгааг хэлээрэй.*

A4.3 Зааварчилгаа өгөх гэж буй хүүхэд бэлгийн хүчирхийллийн тохиолдлын талаар ярьж эхэлбэл зааварчилгаа хэсгийг алгасаж болно.

A5

Үнэнийг мэдүүлэх

Энэ хэсэгт хүүхдэд үнэнийг хэлэхийн ач холбогдлыг тайлбарлаж, үнэнийг хэлэх амлалт авахуулна.

Жишээ: Өнөөдөр чи надад үнэнийг ярих нь чухал юм. Чи ярилцлагын явцад үнэнийг ярина гэж амлаж чадах уу?

- Үнэнийг хэлэхээр хүүхдээс амлалт авах нь түүний үнэн худлыг ярих чадамжийг шалгаж буй хэрэг биш. Хүүхэд үнэнийг ярих тухай амлалт өгснөөр үнэнийг хэлэх магадлал өсдөг.
- Хүүхэд үнэнийг хэлэх амлалт өгөхөөс татгалзвал ярилцлага авч буй хүн үүний учир шалтгааныг асууж болно. Мөн үнэнийг хэлснээр учирч болох эрсдлээс айж буй тохиолдолд хүүхдэд үнэнийг хэлэхийн ач холбогдлыг таниулж, хүүхдийг хамгаалах талаар хэлнэ.

A6

Ярих дадлага хийх (өгүүлэхүйн дасгал)

A6.1 Чамд тохиолдсон зүйлийн талаар өөрийн санаж байгаа бүх зүйлээ надад хэлэх нь маш чухал юм. Сайн, муу аль ч зүйлийн талаар санаж байгаа зүйлээ бүгдийг нь хэлж болно.

A6.2 Хүүхдийн амьдралд саяхан тохиолдсон чухал үйл явдлын талаар яриулж болно. Жишээ нь сургуульд саяхан орсон, төрсөн өдрөө тэмдэглэсэн, ямар нэгэн тэмдэглэлт

арга хэмжээ болсон бол хүүхдээ тэр тухай ярьж өгөхийг хүсч болно. Энэ талаар дараах маягаар хэлж өгнө.

Жишээ:

Саяхан чиний төрсөн өдөр болсон тухай сонслоо. Тэгэхээр төрсөн өдрөө яаж тэмдэглэсэн талаар эргэн санаж байгаад тэр өдөр өглөө сэрснээсээ хойш орой унттал болсон бүхнийг эхнээс нь дуустал нэг ч зүйлийг орхигдуулалгүйгээр ярьж өгөөч.

A6.3 Хүүхдийг ярьж байх үед яриаг нь таслахгүйгээр сайтар сонсож, хүүхэд зогссон тохиолдолд хүүхдийн ярьж байгаад зогссон хэсгээс үргэлжлүүлэн Тэр тоглоомын тухай ярьж өгөөч, гэх мэтээр тодруулах нээлттэй асуулт асууж, хүүхдийн хариултыг үгэн ба үгэн бус байдлаар дэмжих замаар үйл явдлыг дуустал нь яриулна. Хүүхэд төрсөн өдөр болсон зүйлийн тухай бүхэлд нь ярьж дууссаны дараа *Чи олон хүүхдүүдтэй бөмбөгөөр тоглосон тухай хэлж байсан. Тэр тоглоомын тухай илүү дэлгэрэнгүй ярьж өгөөч* гэх мэтээр ярилцана.

A6.4 Хүүхдийг ярьж дууссаны дараа *Чи төрсөн өдрийнхөө талаар маш сайн ярилаа. Тэнд байгаагүй хэдий ч би чиний төрсөн өдөр хэрхэн өнгөрсөн талаар бүгдийг мэдэж авлаа шүү дээ.* гэж хэлж болно.

A7

Саад бэрхшээлийг үнэлэх (RADAR)

Ярилцлага өгөхөд тулгарч буй саад бэрхшээл, ташаа ойлголтыг энэ хэсэгт илрүүлж залруулна. Ярилцлага өгч буй хүүхэд ярилцлагын зорилгыг өөрөөр ойлгосон байх, тухайлбал өөрийгөө эмч, эсвэл сэтгэл зүйчтэй ярилцаж байна гэж бодсон байж болно.

- Санаа нь зовж буй зүйл байгаа эсэхийг тодруулах асуулт тавих замаар илрүүлж болно. Дараах хувилбаруудыг дагана.

Жишээ: Үүнийг хэлсэнд баярлалаа. Чамайг ойлгоход их дөхөм болж байна. Санааг чинь зовоож байгаа зүйлс байгаа ч чи надтай ярилцаж чадах уу? Чамд санаа зовох зүйл байхгүй байгаад баяртай байна. Хэрэв дараа нь санаа зовох зүйл гарвал надад хэлээрэй.

A8

Хүүхдэд тохиолдсон эсвэл тохиолдсон байж болзошгүй бэлгийн хүчирхийллийн талаар олж мэдэх

A8.1 Энэ хэсэгт нээлттэй асуулт асуух замаар ярилцлагыг хөтөлнө. Хүүхдийг тохиолдлын талаар яриулахдаа дараах жишээний тохирохыг хэрэглэнэ. Үүнд:

Жишээ:

- *Чиний талаар бага ч гэсэн зүйлийг олж мэдсэндээ баяртай байна. Одоо хоёулаа чи яагаад энд ирсэн тухай ярилцъя.*
- *Чамайг “ээждээ”, “багшдаа” чамд тохиолдсон зүйлийн талаар ярьсан гэж сонслоо. Чи тэр зүйлийн талаар надад ярьж өгөөч/ өгч болох уу?*
- *Чиний гар хөхөрсөн, шалбарсан, хугарсан, хөл чинь бэртсэн байхыг харлаа. Чи энэ талаар ярьж өгөөч.*
- *Чамайг өнгөрсөн 7 хоногт эмчид үзүүлсэн, цагдаад очсон гэж сонссон. Чи тэдэнд ярьсан зүйлийнхээ талаар ярьж өгөөч.*
- *Ээж чинь, багш чинь чамд тохиолдсон зүйлийн талаар санаа нь зовж байгаа юу? Ээжийнхээ, багшийн чинь санааг зовоож чамд тохиолдсон тэр зүйлийн талаар ярьж өгөөч.*
- *Хэн нэгэн хүн чамд муу зүйл хийсэн байна шүү дээ. Чи тэр талаар ярьж өгөөч.*
- *Чамайг тэнд (хамаатныхаа айлд, зусланд, бэлтгэл дээр) байхад нэг зүйл болсон гэж сонссон. Тэнд чамд тохиолдсон зүйлийн талаар ярьж өгөөч.*

- Нээлттэй асуултын дагуу хүүхэд ярьж байгаад зогсох болон өөр зүйл рүү шилжих үед Дараа нь яасан бэ гэсэн асуултын тусламжтайгаар тухайн тохиолдлыг бүрэн дүүрэн дуустал яриулахыг хичээнэ.

A8.2 Нарийвчилсан асуултуудыг хүүхэд ярилцагчийн асуусан нээлттэй асуултын дагуу хүүрнэл хэлбэрээр хариулж, тохиолдлын талаар бүрэн дүүрэн ярьж дууссаны дараа асууна.

A8.3 Хүүхэд тохиолдлыг дэлгэн хүүрнэн ярьж буй үед ярилцлага хийх удирдамжийн дагуу асуух өөр асуулт байгаа эсэхийг нягтлахаар завсарлага авч болно. Завсарлага авах талаар дараах байдлаар хэлнэ.

Жишээ: ... Одоо бид түр завсарлага авах гэж байна. Өөр асуух асуулт байгаа эсэхийг нягтлах хэрэгтэй байгаа юм. Намайг гарч явсан хойгуур надад хэлэх нь зүйтэй гэж бодсон өөр зүйлс байгаа эсэхийг бодоорой.

A8.4 Тухайн хэрэг зөрчлийг мөрдөн шалгахад цаг хугацааны мэдээлэл чухал. Тухайн хэрэг тохиолдол хэзээ болсон, хэдэн удаа үргэлжилсэн зэргийг мэдэх хэрэгтэй. Гэтэл тохиолдол олон давтамжтай болж байсан бол цаг хугацааг санахад хүнд байдаг. Энэ үед асуултыг дараах маягаар асууж болно.

- Энэ үйл явдал хэзээ болсон талаар санаж байгаа зүйлээ ярьж өгнө үү?

A9

Ярьсан зүйлийг тодруулах

A9.1 Ярилцлага өгч буй хүүхэд яриагаа дуусган, ярилцагч шаардлагатай мэдээллээ олж авсны дараа хүүхдийн ярьсан зарим үг хэллэг, нэр томъёог тодруулж асууна.

Жишээ: Энэ хэсэг эд эрхтнийг өөрөөр нэрлэдэг үү?

Эмч зэрэг мэргэжлийн хүмүүс энэ хэсэг, эд эрхтнийг юу гэж нэрлэдэг вэ?

A9.2 Ярилцагчийн хэлж буй биеийн хэсэг, эд эрхтнийг хүүхэд хэлж чадахгүй бол хүний биеийн диаграмм, үзүүлэн дээр заалгаж болно. Ярилцлага өгч буй хүүхэд ярих зүйлээ дуусгасан бөгөөд зөвхөн түүний бие эрхтнийг нэрлэсэн үг хэллэгийг ойлгох, тодруулах үүднээс биеийн диаграмм, хүүхэлдэй ашиглана.

A10

Өөр таамаглалыг тодруулах

Хүүхэд өөрт нь тохиолдсон боловч хэлж мэдэгдээгүй зүйл үлдсэн байж болзошгүй гэж таамаглан тодруулна. Дараах асуултын хувилбаруудыг асууж болно.

Үүнтэй адил зүйл өөр хэн нэгэнд тохиолдсон уу?

Биеийн чинь бусад хэсэгт бидний яриагүй ямар нэг зүйл болж байв уу?

A11

Гэр бүлийн холбогдолтой асуулт

Гэр бүлийн орчинд эсвэл хүүхдийн гэрт үе үе ирдэг хүн тухайн хэрэг зөрчлийг үйлддэг тохиолдолд гэр бүлийн холбогдолтой асуултыг асууна. Хүүхэд хариулахаас татгалзах, цааргалах байдалтай тохиолдолд ердийн сэдэв болгож асууж болно.

Жишээ: Гэр бүлийн чинь талаар ярилцъя. Чи гэртээ ямар хүмүүстэй хамт амьдардаг вэ?

Жишээ: Чи тэр хүнтэй (сэжиг бүхий этгээд) байхдаа юу хийх дуртай ба дургүй талаараа ярьж өгөөч.

Жишээ: Гэртээ байхад чамд хэцүү байдаг зүйл юу вэ? Ямар үед хэцүү, ямар үед тайван байдаг вэ?

A12

Бие махбодын аюулгүй байдлыг тодруулах

A12.1 Энэ хэсгийн зорилго нь бэлгийн хүчирхийллийн тохиолдлын талаар дурдаагүй, эсвэл ярилцлага авч байгаа зорилгыг ойлгоогүй хүүхдээс мэдээлэл авахад чиглэнэ. Мөн

хожим хойно хэн нэгэн биед нь зохисгүй хэлбэрээр хүрсэн нөхцөлд юу хийх талаар мэдлэг өгөхөд чиглэнэ.

A12.2 Эмчийн үзлэг, өөр гэрчийн ярилцлага зэрэгт тухайн хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй тохиолдолд, эсвэл хүүхэд өмнө нь энэ талаар дурдсан ч ярилцлагын үед үгүйсгэсэн тохиолдолд бие махбодын аюулгүй байдлын талаар хөндөж ярилцана.

A13

Ярилцлагыг төгсгөх

Ярилцлагыг дуусгахдаа дараах зааврыг мөрдөнө. Үүнд:

A13.1 Хүүхдэд талархснаа илэрхийлнэ.

Жишээ: Чи өнөөдөр надад маш их зүйлийг ярьж өгсөнд их баярлалаа.

A13.2 Хүүхдийн үйлдлийг сайшаан дэмжинэ.

Жишээ: Чи өнөөдөр надад өөрт тохиолдсон зүйлийг бүгдийг нь ярьсан нь тун сайн. Чи их зоригтой байсныг би хэлмээр байна. Ийм зүйл олон хүүхдэд тохиолддог ч олон хүүхдүүд энэ талаар бусдад хэлж чаддаггүй. Учир нь тэд айдаг. Чи ч гэсэн айсан байх. Гэхдээ энэ талаар бусад хүмүүст хэлж зоригтой байлаа. Аав ээж чинь чамаар бахархах нь гарцаагүй. Би ч бас чамаар бахархаж байна.

A13.3 Хүчирхийллийн тохиолдлыг цаашид хаана, хэрхэн мэдэгдэхийг тайлбарлана.

Жишээ: Хэн нэгэн чамд таалагдахгүй, хүсэхгүй байдлаар биед чинь хүрвэл аль болох хурдан, аюулгүй байдлаар зугатаад чамд туслах боломжтой том хүнд хэлнэ. Чи тийм зүйл болвол хэнд хэлэх вэ?

A13.4 Нэмэлт мэдээлэл, асуулт байгаа эсэхийг тодруулна.

Жишээ: Чамд надад хэлмээр өөр зүйл байна уу?


Жишээ: Чамд надаас асуух ямар нэгэн асуулт байна уу?

A13.5 Хүүхдэд эргэн холбоо барих мэдээллийг өгнө.

Жишээ: Хэрвээ чи надтай дахин ярилцахыг хүсвэл энэ утсаар над руу холбогдоод дахин энд ирж надтай уулзаж болно. Хүүхдэд өөрийн нэр, утасны дугаарыг өгнө.

7 **В хавсралт**
 8 **Бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг таамаглах индекс**

Зураг 1. Бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг таамаглах индекс



Зураг 2. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдэд илэрч болох зан үйл, сэтгэл хөдлөлийн индексүүд

Бага насны хүүхдэд	Сургуулийн насны ба өсвөр насны хүүхдэд
<ul style="list-style-type: none"> • Бэлгийн шинжтэй зан үйл, үйлдэл гаргах • Тодорхой хүнээс зугатах, зайгаа барих • Хар дарж зүүдлэх, унтаж чадахгүй байх, цочиж сэрэх • Зууралдамтгий болох, эцэг эхээс салахдаа айдастай байх • Айж түгшсэн байх, түгшүүртэй байх • Орондоо шээх • Хичээл сурлага муудах, хичээлээ ойлгохгүй болох • Бие нь улайж загатнах, өвдөлт зовиур хэлэх 	<ul style="list-style-type: none"> • Өөрийгөө гэмтээх • Сэтгэл гутрал/өөрийгөө нийгмээс тусгаарлах • Уур бухимдалтай болох • Айдас, түгшүүрт автах • Тодорхой хүнээс зайгаа барих, зугатах • Сургуульдаа явахаас татгалзах • Хичээл сурлага муудах, • Бие нь улайж загатнах, өвдөлт зовиур мэдрэх • Эрсдэл бүхий зан үйл гаргах-бэлгийн замбараагүй харилцаанд орох, хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох, архи, согтууруулах ундааны хэрэглээ, гэр орноосоо зугатан дайжих

9 С хавсралт

10 Эмнэлгийн тусламж үйлчилгээ ба шүүх шинжилгээний үзэлгийн үед эмч, мэргэжилтний зүгээс хүүхэдтэй харилцах удирдамж

Алхам 1. Хүүхдэд эмнэлгийн үзлэг, тусламжийн тухай тайлбарлаж өгнө. Үүнд:

- Бид чиний биеийн байдал, эрүүл мэндийн байдал зүгээр эсэхийг мэдэхийн тулд эмнэлгийн үзлэг хийх гэж байна. Хэрвээ хүүхэд аюултай нөхцөлд байж, хэн нэгний дарамт хүчирхийлэлд өртсөн бол хүүхдэд халдвар туссан эсвэл бэртэж гэмтсэн байж болзошгүй. Эмчид үзүүлж шинжилгээ хийснээр халдвар байгаа эсэхийг олж мэдээд шаардлагатай эмчилгээг хийх боломжтой болно.
- Өндөр эрсдэлтэй бэлгийн зан үйл бүхий өсвөр насны хүүхдэд жирэмслэлтийн тохиолдол байж болох тухай хэлэхийн хамт хүсээгүй жирэмслэлтийг эрт мэдэх тусам жирэмслэлтийг зогсоох боломжтой байдаг тухай нэмж хэлнэ. Мөн жирэмслэхийг хүссэн байж болох тохиолдолд эрт мэдэх тусам эх, хүүхдийн эрүүл мэндэд хэрэгтэй тусламжийг эрт үзүүлэх боломж бүрдэнэ гэдгийг хэлнэ.

Алхам 2. Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчаас таниулсан зөвшөөрөл авна.

- Биеийн үзлэг, шинжилгээ, оношилгооны талаар хүүхдэд өөрт нь болон эцэг эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгчид урьдчилан мэдээлэл өгч, тайлбарлан ойлгуулсны үндсэн дээр үзүүлэх

Алхам 3. Хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг стандарт зааврын дагуу үзүүлнэ.

- Хүүхдийг дахин гэмтэх, хоёрдогч хохирогч болохоос урьдчилан сэргийлэх үүднээс эрүүл мэндийн нэг үзлэгээр шаардлагатай бүх үзлэг, шинжилгээ, оношилгоог хийх;
- Эрүүл мэндийн үзлэг, оношилгооны үед эмч, мэргэжилтний зүгээс хийх гэж буй алхам үйлдэл бүрийнхээ өмнө хүүхдэд хэлж тайлбарлаж өгөх;
- Эрүүл мэндийн үзлэг шинжилгээний үеийн эмнэлгийн багаж хэрэгслийг хэрэглэхдээ хүүхдэд учруулах өвчин зовиур, таагүй байдлыг багасгахад анхаарах;
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний зүгээс эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ хүүхэдтэй эелдэг хүндэтгэлтэй харилцаж, ярилцах үедээ хүүхдийн хөгжил, сэтгэл зүй, насны онцлогт тохирсон энгийн үг хэллэг хэрэглэхийн хамт хүүхдийг буруутгасан үг, үйлдэл, хандлага гаргахгүй байхад анхаарна.

Алхам 4. Үзлэгийн тэмдэглэл хөтлөх, баримт нотолгоог хадгална.

- Эмч мэргэжилтний зүгээс эмнэлгийн үзлэгийн тэмдэглэл, үйлчлүүлэгчийн өвчний түүх, оношилгоо, шинжилгээний үр дүн, дүгнэлт, нотолгоог зохих журмын дагуу хадгалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримт болгох, хохирогчид шаардлагатай эмчилгээг төлөвлөн үзүүлэх, үр дүнг хянах болон бусад зорилгоор ашиглана.

11 D хавсралт**12 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн тухай үзлэгийн****13 тэмдэглэл хөтлөх, баримтжуулах нь**

Хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн үзлэг, шинжилгээ, эмчилгээний явцад цуглуулсан мэдээлэл, хүүхдийн өвчний түүх, биеийн эрүүл мэндийн ба сэтгэл зүйн байдал, өвчлөл, гэмтэл, бэртлийн байдал ба бусад холбогдох мэдээлэл, баримт нотолгоо, дараагийн шаардлагатай эмчилгээ, үйлчилгээний төлөвлөгөө зэргийг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтын хэмжээнд ашиглах зорилгоор нарийвчлан, бүрэн дүүрэн хөтөлж, баримтжуулалт хийнэ. Үүнд:

D1 Тэмдэглэлийг батлагдсан маягтын дагуу хөтлөх, гарын үсэг зурж баталгаажуулах;

D2 Хүүхэд, түүний эцэг эх эх, асран хамгаалагчийн хэлсэн үг яриа, тайлбарыг бичиж тэмдэглэх, ялангуяа бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хэлсэн үг, яриа, тайлбарыг нэг бүрчлэн дэлгэрэнгүй бичиж тэмдэглэх;

D3 Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийн үг яриа, тайлбар зөрчилдөж буй тохиолдолд энэ талаар бичиж тэмдэглэх;

D4 Хүүхдийн биед учирсан бэртэл гэмтлийн байдал, шинж тэмдгийг дэлгэрэнгүй дүрслэн тэмдэглэх;

D5 Хүүхдийн сэтгэл зүйн байр байдлыг бичиж тэмдэглэх;

D6 Хүүхдийн бие махбодод ил харагдах бэртэл гэмтэл ажиглагдаагүй байж болох ч энэ нь хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөөгүй гэсний баталгаа болохгүй гэдгийг анхаарах;

Бэлгийн хүчирхийллийн тохиолдолд нотлох баримт цуглуулах нь	
Тайлан бэлтгэх	Нотлох баримтыг тайлбарлах, хамгаалах
1. Хүүхдээс сонссон ба ажигласан зүйлээ бичиж тэмдэглэх	1.Бэлтгэлтэй байх
2. Тодорхой нэр томьёо үг хэллэг хэрэглэх	2.Анхааралтай сонсох
3. Объектив байх	3.Тодорхой ярих
4. Нотолгоо ба үзэл бодлыг ялгаж салгах	4.Өөрийн салбарын хүрээнд ярих
5. Цуглуулсан бүх нотлох баримт, дээжийн шинжилгээний үр дүнг дэлгэрэнгүй бичиж тайлбарлах	5.Аль нэг талыг барихгүй байх

D7 Таниулсан зөвшөөрлийг авч хавсаргасан байх, ялангуяа үзлэгийн үеэр зураг авч, бичлэг хийсэн бол хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид тухайн мэдээллийг ямар зорилгоор, хэрхэн ашиглах тухай танилцуулж зөвшөөрөл авсан байх;

D8 Үзлэгийн тэмдэглэл, нотлох баримт зэргийг багтаасан хохирогч хүүхдийн өвчний түүхийг нууцлалтай хадгалах;

D9 Хэвлэмэл, бичмэл материалыг цоожтой, доторх нь харагдахгүй хаалгатай шүүгээнд, цахим мэдээллийг нууц үгээр хамгаалагдсан компьютер ба файлд хадгална.

D10 Хүүхдийг мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох;

D11 Хэвлэмэл мэдээлэл, олон нийтэд мэдээлэхгүй байх;

D12 Зөвшөөрөл авсны үндсэн дээр албан ёсны эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэнд нууцлалын гэрээ байгуулсны үндсэн дээр мэдээллийг хуваалцах;

Хүүхэд ялангуяа өсвөр насныхантай HEADSSS аргаар нийгэм сэтгэл зүйн байдлыг үнэлэхийг ДЭМБ -аас зөвлөмж болгосон байдаг. Энэ үнэлгээ нь хүүхэд өөрөө хэлээгүй, илэрхийлээгүй эрүүл мэндийн болон гэр бүл, орчны, нийгмийн асуудал, хүүхдийн зан үйл, эрсдэлт зан үйлийг илрүүлэхэд тустай.

Хүүхэд, өсвөр үеийнхний өөрсдийнх нь хэлсэн зовиур, мэдээллээс гадна тусгайлсан асуулт асуухгүй л бол бодит байдлаа огт хөндөхгүй, ярихгүй өнгөрөх магадлалтай. Айж, ичиж санаа зовсоноосоо болоод хэрэгцээт тусламжаа авч чадахгүй өнгөрөх тохиолдол ч гарахыг үгүйсгэхгүй.

Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсон, жирэмсэн, жирэмсэн байж болзошгүй, хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй, амиа хорлох бодол, оролдлого, хорт зуршил байгаа зэргийг тооцож эрсдэлтэй гэж үзвэл шаардлагатай эмнэлгийн болон нийгэм сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэнд, хамгаалал, хуулийн тусламж үйлчилгээнд холбон зуучлах шаардлагатай болно.

	Эрсдлийн хүрээ	Тодруулах асуултууд
H	(Home) Гэр бүлийн байдал	Чи гэртээ хэнтэй хамт амьдардаг вэ? Гэр чинь хаана байдаг вэ? Гэрт чамд өөрийн гэсэн хувийн орон зай хангалттай байдаг уу? Чи гэртээ байх дуртай юу? Гэр чинь чиний хувьд аюулгүй, тайван газар мөн үү?
E	(Education) Боловсрол	Чи сургуульд явдаг уу? Сургууль дээр чамд ямар байдаг вэ? Сургуульд явахад хүнд хэцүү зүйл байна уу? Хэрэв сургууль дээр чинь асуудал гарвал энэ үед чамд туслах хүн байгаа юу?
A	(Activities) Үйл ажиллагаа	Сургуулиас гадуур ямар нэгэн үйл ажиллагаанд оролцдог уу?
D	(Drugs, alcohol and smoking) Архи, согтууруулах ундаа, тамхи, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ	Чамд архи, тамхи хэрэглэдэг найз байдаг уу? Чи өөрөө эдгээрийг хэрэглэдэг үү? Хэн нэгэн чамд хүчээр эсвэл чамайг мэдээгүй байхад хэрэглүүлсэн тохиолдол байдаг уу?
S	(Social media) Нийгмийн сүлжээ	Цахим орчинд чамд таагүй санагдахуйц ямар нэгэн зүйл болж байсан уу?
S	(Suicide, Depression, Anxiety) Амиа хорлолт, сэтгэл гутрал, түгшүүр	Чамд сэтгэлээр унах, түгших мэдрэмж төрж байсан уу? Сэтгэл санаагаар унаж, санаа зовж түгших явдал тохиолддог уу?
S	(Sexuality) Бэлгийн амьдрал	Чи бэлгийн харилцаанд орж байсан уу? Чамд бэлгийн харилцаатай холбоотой санаа зовох зүйл эсвэл тусламж авах хэрэгцээ шаардлага байна уу?

²⁷ Охидод эрүүл мэндийн өвөрмөц тусламж үйлчилгээ үзүүлэх заавар. ЭМС-ын 2020 оны 6 сарын 30-ны А/364 дүгээр тушаалын хавсралт

Ном зүй

Гадаад хэл дээр

World Health Organization (WHO). Guidelines for medico-legal care for victims of sexual violence; 2003

Seshadri S, Ramaswamy S. Clinical practice guidelines for child sexual abuse. Indian J Psychiatry 2019; 61:317-32

United Nations Children's Fund (UNICEF) and International Rescue Committee (IRC), "Caring for Child Survivors of Sexual Abuse Guidelines", Second Edition, UNICEF, New York, 2023

World Health Organization (WHO), United Nations Population Fund (UNFPA), United Nations High Commissioner for Refugees (UNHCR). Clinical management of rape and intimate partner violence survivors: developing protocols for use in humanitarian settings. Geneva: World Health Organization; 2020. Licence: CC BY-NC-SA 3.0 IGO.

Монгол хэл дээр

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төсөл. 2022. Цагдаагийн байгууллагад хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зөвлөмж.

СЭМҮТ. 2020. Хүчирхийллийн хохирогч ба үйлдэгчид үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ. Улаанбаатар хот.

Хүүхдийг Ивээх сан. Хүүхэд хамгааллын кейс менежментийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн гарын авлага. Улаанбаатар хот. 2020 он.

Хүүхдийг Ивээх Сан. Хамтарсан багийн гишүүн өөрийн болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж. 2019 он.

Хүүхдийг Ивээх Сан. Хамгааллын алхмууд. Кейс менежментийн нийтлэг арга зүй. 2020 он. Улаанбаатар хот.

Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллага., IRIM судалгааны хүрээлэн. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, 2021

Хүүхдийг Ивээх сан. 2023. Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч, даван туулагсдад үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ. Модуль 11. Улаанбаатар хот. (Боловсруулсан: Д.р. Зууннастын Хишигсүрэн, Даваасүрэнгийн Оюунсүрэн)

ЭМСЯ, Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн хөгжил шинэчлэлийн хүрээлэн, НҮБХАС. 2019. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээний төвтэй холбоотой бодлогын баримт бичгийн нөхцөл байдлын үнэлгээ.

Хүүхдийг Ивээх Сан (2014). Удирдамж: Сэжиглэж буй зүй бус харьцаа, бэлгийн мөлжлөгийн кейстэй ажиллах нь. Лондон: Хүүхдийг Ивээх Сан

Олон улсын авран хамгаалах хороо. (2012). Бэлгийн зүй бус харьцааг даван туулагч хүүхдүүдийг асран хамгаалах нь

УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судлах хүрээлэн. 2019. Бага насны хүүхдийн эсрэг чиглэсэн бэлгийн хүчирхийллийн суурь судалгаа

Өсвөр үеийн эрүүл мэндийн тандалт, эрүүл мэндийн үзүүлэлтийн маягт, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны тусламж, урьдчилан сэргийлэх үзлэг, нэр томъёоны тайлбар, тандалтын мэдээллийн урсгалын журам, 2021, А/97

Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох аргачлал судалгаа. УБ

ХЭҮК, ЦЕГ, ДХИС, ХЭҮТ, Хөөрхөн зүрх ТББ, НҮБ-ын Хүүхдийн сан. 2022. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь (Цагдаагийн албан хаагчид зориулсан гарын авлага).

ХЭҮК, ЦЕГ, ДХИС, ХЭҮТ, Хөөрхөн зүрх ТББ, НҮБ-ын Хүүхдийн сан. 2022. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ (эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан гарын авлага)

Монгол улсын стандартууд

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6418:2013

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS 5852:2017

Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага, MNS 6949:2021

Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS 6040:2019

Журам, зааврууд

ХНХЯ. 2017. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам

ХЗДХЯ. 2017. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам.

ЭМЯ. 2022. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар

ХНХЯ. 2017. Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх журам.

ХНХЯ. 2017. Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзах уулзалтыг зохион байгуулах журам

ЭМЯ, ХЗЯ. 2014. Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам, А/356, А/182 дугаар тушаалын хавсралт

ХЗЯ. 2014. Гэрч хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам, А/114 дүгээр тушаал

ЭМЯ. 2019. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм. А/406 дүгээр тушаалын хавсралт.

ЭМЯ. 2020. Охидод эрүүл мэндийн өвөрмөц тусламж үйлчилгээ үзүүлэх заавар. А/364 дүгээр тушаалын хавсралт

ЭМЯ. 2022. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар, А/151 дүгээр тушаалын хавсралт

ЭМЯ. 2022. Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх заавар, А/149 дүгээр тушаалын хавсралт

ЭМЯ. 201. БЗДХ, ХДХВ, ДОХ-н тусламж үйлчилгээ үзүүлэх журам, А/305 тушаалын хавсралт

ЭМЯ. 2019. Үр хөндөлтийг зохицуулах журам. А/387 тушаалын хавсралт

БСШУСЯ. 2018. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам. А/612 дугаар тушаалын хавсралт